МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

unicef НҮБ-ын Хүүхдийн Сан

World Health Organization

# БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН СУДАЛГАА-2023

Улаанбаатар хот
2024 он

“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа-2023” үндэсний хэмжээний түүвэр судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан болон ДЭМБ-ын техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр явуулав.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,

Нэгдсэн Үндэстний гудамж-5

Утас: +(976) 51-261553

Факс: +(976) 11-328634

Цахим хуудас: www.mlsp.gov.mn

И-мэйл: info@mlsp.gov.mn

# ӨМНӨХ ҮГ



"Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйлийн судалгаа-2023" үндэсний хэмжээний түүвэр судалгааг амжилттай зохион байгуулж үр дүнгийн тайлангаа хүргүүлж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалаар хийсэн ерөнхий боловсролын сургуульд суралцагч 13-17 насны хүүхдүүдийг үндэсний болон хот хөдөөгийн суурьшлаар төлөөлөх хэмжээний түүвэртэй анхны судалгаа юм. Энэхүү судалгааны дүн нь үндэсний бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нар, олон улсын болон хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагуудад бодлого, хөтөлбөрийг тодорхойлоход ашиглах суурь мэдээлэл болохын зэрэгцээ, эрдэмтэн судлаачдад гүнзгийрүүлсэн судалгаа, шинжилгээний ажил хийхэд чухал эх үүсвэр болох юм.

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (ХЭК)-д 1990 онд нэгдэн орж, конвенцын үзэл санаа, зарчимд нийцүүлэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталж, 2016 онд хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын орчныг сайжруулж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн тулд уг хуулийг Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай гэх бие даасан хоёр хууль болгон баталж, хүүхэд бүрийг аливаа төрлийн хүчирхийллээс ангид байх, эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох эрхийг баталгаажуулсан. Дээрх хуулиуд болон Тогтвортой хөгжлийн 4 болон 16.2 дугаар зорилтуудын хэрэгжилтийн үр дүнг тооцох, олон улсын түвшинд харьцуулагдахуйц, чанарын болон тоон мэдээ, мэдээллийн сан бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна.

Үндэсний хэмжээний судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судлалын үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулахад ажлын хэсгийн гишүүн бүрийн хүчин зүтгэл маш их байсныг үүгээр тэмдэглэхийг хүсэж байна. Мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн судлаачдаас гадна орон нутгийн удирдлага, боловсролын газрын хамт олон техник арга зүйн болон бусад шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлсэн бөгөөд тэдний манлайллыг онцлох нь зүйтэй.

Судалгааны арга зүй боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгч, хамтран ажиллаж, санхүү, техникийн дэмжлэг үзүүлж байгаа НҮБ-ын Хүүхдийн

сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, хамтран ажилласан яамдын асуудал эрхэлсэн албан хаагчид болон мэргэжлийн судлаачдад талархал илэрхийлье.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад оролцож, хувийн мэдээллээ хуваалцсан нийт хүүхдүүд, тэднийг судалгаанд оролцуулах зөвшөөрлийг өгсөн эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхдийн эрх, хамгааллын талаар үнэтэй санал дүгнэлт өгсөн багш нарт онцгойлон талархал илэрхийлж байна.

Бид хамтдаа Монгол Улсын хүүхдийн эрх, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажиллаж, Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх чухал алхмуудын нэгийг тавьж байгаа юм. Монгол Улсын хүүхдэд ээлтэй байдлыг сайжруулахад тус судалгаа хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД Х.БУЛГАНТУЯА

# ӨМНӨХ ҮГ



Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, сургуулийн орчинд хүүхдийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, шийдвэрийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар цэцэрлэг, сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчинд сурч хөгжих боломж бүрдүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшил, хамгаалалд нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, сургалтын байгууллага, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, түншлэлийн асуудлыг тусгайлан зохицуулсан.

Коронавируст халдварын цар тахал нөлөөгөөр боловсролын салбарт урьдчилан тооцох боломжгүй эрсдэл, үр дагавар бий болсон хэдий ч хичээл, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэн тасралтгүй үргэлжлүүлж, дижитал технологи ашиглан суралцах ур чадварт багш, суралцагчид хамтдаа суралцсан онцлог жилүүдийг туулллаа. Цар тахлын улмаас суралцагчдын 76 хувь нь сэтгэл зовинолтой, 6-13 насны хүүхдүүд стресс бухимдал хэвийн үзүүлэлтээс өндөр, суралцагчдын дийлэнх нь сурлагаар хоцрогдохоос айж байгаа зэрэг асуудал судалгаагаар гарсан. Хүүхдүүдийн дунд үүссэн айдас, сэтгэл зүйн дарамтыг багасгахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдэхэд туслах, зөвлөгөө өгөх зорилгоор “Боловсролын сэтгэл зүйч”-ийг ерөнхий боловсролын сургуульд 2021 оноос ажиллуулж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийт сургуулийн гуравны хоёрт нь боловсролын сэтгэл зүйч ажиллаж байна.

Бага ангийн хүүхдүүдийг “Үдийн цай” хөтөлбөрөөс “Үдийн хоолны үйлчилгээ”-нд 2020 оноос шилжүүлсэн нь тэдний сурч боловсрох эрхийг хангахад бодит дэмжлэг болж байна.

Сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын тогтолцоо бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагаа сургуульд суурилан зохион байгуулахаар эрх зүйн орчныг бүрдүүлэн хэрэгжүүлж эхэллээ.

Төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн

байгууламжаар солих арга хэмжээг авч хэрэгжүүлэн 853 нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих арга үе шаттай авч хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургууль бүрт нийгмийн ажилтан ажиллаж эхэлснээс хойшхи 20 гаруй жилийн хугацаанд хүүхдийн эрхийн нөхцөлийг сайжруулахад багагүй хувь нэмэр оруулсныг энд цохон тэмдэглэмээр байна. Боловсролын салбарт эрх зүйн шинэчлэл үе шаттай хийгдэж байгаа хэдий ч өдөр тутмын амьдралд хүүхдийн эрх зөрчигдөх, эрсдэлт нөхцөл үүсэх явдал гарсаар байна.

Боловсролын хувирган өөрчлөлт, цахим сургалтын системийн хөгжил, хичээл сургалтын зохион байгуулалтад гарч буй өөрчлөлт, тэгш бус байдал болон сургуулийн орчин дахь дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт зэрэг нь хүүхдийн сурч боловсрох эрх төдийгүй суурь эрх зөрчигдөх, ялгаатай байдлыг улам бүр нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа нь бидний анхаарал хандуулах асуудлын нэг болж байна.

Сургуулийн орчин, нөхцөлийг сайжруулах, хүүхдийг аливаа болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний аюулгүй байдлыг хангахад тэргүүлэх чиг үүрэг бүхий Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам хамтран энэхүү судалгааг зохион байгуулсан нь салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, судалгааны үр дүнгээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хүүхдийг аливаа үйл ажиллагаанд оролцох тэгш боломжоор хангах, суралцагчийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн эрүүл, аюулгүй ээлтэй орчин бүрдүүлж, хууль тогтоомжоор үүрэг хүлээгчид хүлээсэн үүрэгтээ онцгой анхаарал хандуулах шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байна.

Судалгааны үр дүнг өөрийн мэргэжил, эрхлэх ажлын хүрээнд бүтээлчээр ашиглах өргөн боломж Та бүхэнд бүрдлээ.

Суралцагч бүрд чанартай боловсролыг эзэмшүүлэх, тэгш боломжийг бүрдүүлэх, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд энэхүү судалгаа үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

# ӨМНӨХ ҮГ



Хүүхдийн эрхийн комиссын гишүүн орнууд хүүхдийн эрхийн хэрэгжилт, хамгааллын хүчин зүйлийн талаар тогтмол судалгаа хийж, хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьсан бодлого шийдэл гаргаж, үүсэн гарсан асуудал бэрхшээлийг хүүхдэд ээлтэйгээр шийдвэрлэх үүрэг хүлээдэг. Энэ үүргийнхээ хүрээнд 2023 онд Монгол Улс "Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа-2023" үндэсний хэмжээний түүвэр судалгааг зохион байгуулсанд НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн хувьд би их баяртай байна.

Өсвөр нас бол хүүхдийн амьдралын хурдацтай өөрчлөлтийн үе юм. Энэ насандаа (10-19 нас) охид, хөвгүүд эсэн мэнд амьдрах, хөгжих, оролцох, хамгаалагдах эрхээ хэрхэн эдэлснээс тэдний цаашдын аж амьдрал, улс орных нь хөгжил цэцэглэлт ихээхэн хамаардаг. Монгол Улс өсвөр насны хүүхдүүдийнхээ эрх, хамгааллын өнөөгийн нөхцөл байдлын талаар үндэсний хэмжээний судалгаа хийж, тэдний төлөө хийж хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн суурь мэдээлэлтэй болж байна.

Судалгааг хамтран хэрэгжүүлсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам болон эдгээр яамдын харьяа байгууллагууд болох Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтэд талархал дэвшүүлье.

Монгол Улс сүүлийн жилүүдэд хүүхдийн эрх, хамгааллыг бэхжүүлэх талаар томоохон ахиц амжилт гаргалаа. УИХ-аас Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгыг баталж хүүхэд хамгааллын төсвийг нэмлээ. Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудад өсвөр насны хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, сургууль, дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамран сургах талаар хүүхдэд ээлтэй заалтууд орж батлагдлаа. Үндэсний хэмжээнд өсвөр насны хүүхдийн оролцоотой хийгдсэн энэхүү судалгааны үр дүн нь цаашдаа эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ ЭВАРИСТЕ КОУАССИ-КОМЛАН

# АГУУЛГА


ӨМНӨХ ҮГ ....................3
ӨМНӨХ ҮГ ....................5
ӨМНӨХ ҮГ ....................7
АГУУЛГА ....................8
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ....................10
ЗУРГИЙН ЖАГСААЛТ ....................12
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ....................14
ТОВЧ ДҮГНЭЛТ ....................15
Эсэн мэнд амьдрах эрх ....................15
Хөгжих эрх ....................16
Оролцох эрх ....................17
Хамгаалуулах эрх ....................18
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ....................19
Монгол улсын талаар үндсэн мэдээлэл ....................20
Хүн амын тоо, өөрчлөлт ....................21
1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ ....................23
1.1. Үндэслэл ....................23
1.2. Судалгааны зорилго ....................25
1.3. Хүлээгдэж буй үр дүн ....................25
1.4. Судлагдсан байдал ....................25
1.5. Судалгааны арга зүй ....................27
1.6. Түүврийн зохиомж ба судалгааны хамрах хүрээ ....................27
1.7. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт ....................31
1.8. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт ....................32
1.9. Нууцлал болон ёс зүйн асуудал ....................33
2. ЭСЭН МЭНД АМЬДРАХ ЭРХ ....................35
2.1. Сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий үнэлгээ ....................37
2.2. Сургуулийн гадаад орчны үнэлгээ ....................39
2.3. Сургуульд хүрэх замын аюулгүй байдал ....................41
2.4. Сургуулийн дотоод орчин ....................43
2.5. Жендэр ба аюулгүй байдал ....................44
2.6. Гамшгийн бэлэн байдал ....................46
2.7 Дотуур байрны орчны аюулгүй байдлын үнэлгээ ....................48
ДҮГНЭЛТ ....................50

3. ХӨГЖИХ ЭРХ ........................................................................................53
3.1 Сургуулийн орчин дах хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээ ..........55
3.2 Хөгжлийн үйлчилгээний хүртээмж ........................................................55
3.3. Спортоор хичээллэх боломж ..................................................................56
3.4. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны төрлүүд........................................57
3.5. Хүүхдийн ордон, хөгжлийн төвийн үйлчилгээ .......................................58
3.6. Ном унших дадал.......................................................................................59
3.7.  Зуны амралт...............................................................................................61
ДҮГНЭЛТ .......................................................................................................62
4. ОРОЛЦОХ ЭРХ.............................................................................................65
4.1. Өөрт хамааралтай шийдвэр гаргалтад оролцох .....................................66
4.2. Санал асуулгад оролцох ..........................................................................66
4.3. ИТХ-ын шийдвэрт нөлөөлөх ....................................................................67
4.4. Хүүхдийн оролцооны байгууллагууд .......................................................68
4.5. Сайн дурын ажил .......................................................................................69
ДҮГНЭЛТ ........................................................................................................70
5. ХАМГААЛУУЛАХ ЭРХ ..................................................................................72
5.1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлс.........75
5.2. Үе тэнгийнхний дээрэлхэлт, бие махбодын шийтгэл ...........................76
5.3. Цахим орчны хүчирхийлэл.......................................................................77
5.4. Хариу үйлчилгээнд хамрагдах чадамж....................................................77
5.5. Уралдаанч хүүхдийн нас...........................................................................80
5.6. Хүүхдийн хөдөлмөрийн зохицуулалт ......................................................81
ДҮГНЭЛТ .........................................................................................................81
6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХ ................................................83
6.1. Сургуулийн орчны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал ...83
6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөгжлийн үйлчилгээний хүртээмж ..........................................................................................................85
6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах үе тэнгийнхний үзэл бодол.86
ДҮГНЭЛТ ..........................................................................................................87
АШИГЛАСАН МАТЕРИАЛ....................................................................................89
ХАВСРАЛТ...........................................................................................................93

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын хүн ам зүйн үзүүлэлтүүд....22
Хүснэгт 1.1. Судалгаанд хамрагдсан ТАШН, бүс, аймгаар ....30
Хүснэгт 2.1. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, насны бүлгээр, дунд эзлэх хувиар, 2023 он....38
Хүснэгт 2.2. Сургуулийн эргэн тойрны 150 м хүртэлх газарт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт, байршлаар....39
Хүснэгт 2.3. Сургуулийн гадаа талбайн 25 хүртэлх хувьд ногоон байгууламжтай эсэх, байршлаар ....40
Хүснэгт 2.4. Сургуулийн эзэмшил газар хашаалагдсан байдал, байршлаар 40
Хүснэгт 2.5. Сургуулийн гадаад орчны гэрэлтүүлгийн хүртээмж, байршлаар....41
Хүснэгт 2.6. Сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга бүхий самбар байршуулсан байдал, байршлаар ....42
Хүснэгт 2.7. Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн талаар хэрэгжүүлэх дотоод хяналтын байдал, байршлаар....43
Хүснэгт 2.8. Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, байршлаар....43
Хүснэгт 2.9. Ус цэвэршүүлэгч байршуулсан байдал, байршлаар ....44
Хүснэгт 2.10. Биеийн тамирын зааланд эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хувцас солих орчныг тусгаарласан байдал, байршлаар....45
Хүснэгт 2.11. Эмэгтэй сурагчдын ариун цэврийн өрөөний халуун усны хангамж, байршлаар....45
Хүснэгт 2.12. Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй эсэх, байршлаар...46
Хүснэгт 2.13. Урлаг, соёлын танхимын гарц, тэмдэглэгээ байрлуулсан байдал, байршлаар ....47
Хүснэгт 2.14. Гамшгийн үед авах арга хэмжээг дүрсэлсэн тэмдэг тэмдэглэгээний байдал, байршлаар....47
Хүснэгт 2.15. Сургуулийн гадна талбайн хүртээмжтэй байдал, байршлаар 47
Хүснэгт 2.16. Дотуур байртай эсэх, байршлаар ....48
Хүснэгт 2.17. Дотуур байрны эзэмшил газрын хашаалагдсан байдал, байршлаар....48
Хүснэгт 2.18. Дотуур байрны эзэмшил газрын автомашины зогсоол байгуулаагүйд анхаарсан байдал, байршлаар ....48

Хүснэгт 2.19. Давхар бүрд хүүхэд амрах булан байгуулсан байдал, байршлаар....49
Хүснэгт 2.20. Эцэг, эх хүүхэдтэйгээ чөлөөтэй уулзах боломжийг хангасан уулзалтын өрөөтэй эсэх, хувиар, байршлаар....49
Хүснэгт 2.21. Сургуулийн дотуур байрны өрөөнүүд хүйсийн хувьд тусдаа байдаг эсэх, байршлаар....50
Хүснэгт 3.1. Сургуулийн орчинд хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан байдал, насны бүлгээр....55
Хүснэгт 4.1. Өсвөр насныхны шийдвэр гаралтад оролцсон байдал, хувиар 66
Хүснэгт 5.1. Сүүлийн 12 сарын хугацаанд огт уулзаж танилцаагүй хүнтэйгээ интернэт орчинд харьцсан байдал, ангиар....77

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Монгол Улсын засаг захиргааны нэгж, аймаг, нийслэлээр........20
Зураг 1.1. Судалгааны түүврийн хүрээ "Хотын сургуулиуд"........................28
Зураг 1.2. Судалгааны түүврийн хүрээ "Хөдөөгийн сургуулиуд" ................28
Зураг 2.1. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, байршлаар.......................................................37
Зураг 2.2. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, байршлаар.......................................................39
Зураг 2.3. Сүүлийн 1 сарын хугацаанд сургуульд ирж, очсон байдал, байршлаар.........................................................................41
Зураг 2.4. Сургууль хүрэх замд буй бэрхшээлүүд, байршлаар....................42
Зураг 2.5. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан эсэх, хүйсээр.............................................................44
Зураг 2.6. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуульдаа ирж очих замд ямар нэг саад бэрхшээл учирсан эсэх, хүйсээр...................................46
Зураг 2.7. Ариун цэврийн байгууламж хүрэх замын аюулгүй байдал, байршлаар.........................................................................49
Зураг 3.1. Сургуулийн орчинд хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан байдал, хүйсээр, байршлаар ...................................55
Зураг 3.2. Хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй шалтгаан, байршлаар.........................................................................56
Зураг 3.3. Сургуулийн орчим ямар нэг спортоор хичээллэх, тоглох боломж 57
Зураг 3.4. Сүүлийн 12 сарын хугацаанд Хүүхдийн хөгжлийн ордон, хүүхдийн хөгжлийн төвөөс явуулдаг урлаг, спортын ямар нэгэн секц, клуб, сургалт, дугуйланд хамрагдаагүй шалтгаан, хүйсээр ................58
58
Зураг 3.5. Өнгөрсөн нэг сарын хугацаанд ном уншихад зарцуулсан дундаж хугацаа, цагаар ...................................................................59
Зураг 3.6. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж......................59
Зураг 3.7. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, байршлаар 60
Зураг 3.8. Хүүхдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, хүйсээр ............60
Зураг 3.9. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, насаар.........61
Зураг 3.10. Зуны амралтыг өнгөрүүлж буй байдал, хүйсээр .........................62
Зураг 4.1. Хүүхэд өөрийн хамааралтай асуудлаар шийдвэр гаргалтад оролцсон байдал, хүйсээр ........................................................66
Зураг 4.2. Сургуулийн орчинд хичээлээс гадуур явуулах үйл ажиллагааны талаарх санал асуулга явагдсан байдал, ангиар .........................67

Зураг 4.3. Оршин суугаа газрын ИТХ-аас хүүхдүүдийн саналын дагуу аливаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байдал, хүйсээр, байршлаар ....68
Зураг 4.4. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хүйсээр, байршлаар ....69
Зураг 4.5. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоо, ангиар ....69
Зураг 4.6. Сайн дурын ажилд оролцсон байдал, хүйсээр, байршлаар ....70
Зураг 5.1. Сүүлийн 7 хоногт хамт амьдарч байсан хүн, байршлаар ....76
Зураг 5.2. Хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл шаардлагатай эсэх, хүйсээр, байршлаар....76
Зураг 5.3. Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт орчинд танилцсан хүнтэй биечлэн уулзсан байдал, хүйсээр ....77
Зураг 5.4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл авсан тохиолдолд авах арга хэмжээ, хувиар....78
Зураг 5.5. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл авсан тохиолдолд авах арга хэмжээ, хүйсээр....79
Зураг 5.6. Хурдан морийг унах тохиромжтой хүний талаар үзэл бодол, хувиар ....80
Зураг 5.7. Хурдан морийг унах тохиромжтой хүний талаар үзэл бодол, хувиар ....80
Зураг 5.8. Өсвөр насны хүүхдүүдийг оройн цагаар урлаг, спорт болон бусад арга хэмжээнд оролцуулахын өмнө эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах талаар хуулийн заалтын хэрэгжилтийн байдал, хүйсээр, байршлаар ....81
Зураг 6.1. Сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал....84
Зураг 6.2. Сургууль дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулдаг дугуйлан, секц, оролцооны клуб, зөвлөл байгаа эсэх талаар хүүхдийн мэдлэг, хүйсээр, байршлаар....85
Зураг 6.3. Сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал, байршлаар....86
Зураг 6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шилжин ирсэн тохиолдолд хандах хандлага, хүйсээр....87

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| **БОХЭХС** | Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа |
| **ХНХЯ** | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| **НҮБ** | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| **ДЭМБ** | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага |
| **ОХУ** | Оросын Холбооны Улс |
| **БНХАУ** | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| **ХЭК** | Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц |
| **ГБХЗХГ** | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| **НҮББШУСБ** | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага |
| **ОУБ** | Олон Улсын Байгууллага |
| **ТАШН** | Түүврийн Анхан Шатны Нэгж |
| **ЭМЯ** | Эрүүл Мэндийн Яам |
| **ҮСХ** | Үндэсний Статистикийн Хороо |
| **ЕБС** | Ерөнхий Боловсролын Сургууль |
| **НҮБХС** | НҮБ-ын Хүүхдийн Сан |
| **ОУХБ** | Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага |

# ТОВЧ ДҮГНЭЛТ

Өсвөр насны хүүхдийн эрх, хамгааллын өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу цогц мэдээллийг цуглуулах, боловсруулах, бодлого, хөтөлбөрийн үр дүнг хэмжих, цаашдын суурь мэдээллийг бий болгох зорилгоор энэхүү судалгааг хийлээ.

Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын судалгаа (БОХЭХС) нь 3284 хүүхдийг хамарсан үндэсний хэмжээний төлөөлөлтэй түүвэр судалгаа бөгөөд 13-17 насны дунд, ахлах ангийн сурагчдаас авсан. Судалгааг ХНХЯ-ны санаачилгаар НҮБ-ын Хүүхдийн Сан, ДЭМБ-ын санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судалгааны үндэсний төв хамтран 2022 оны 9 дүгээр сараас 2023 оны 4 дүгээр сарын хооронд бэлтгэлийг хангаж мөн оны 4--өөс 5 дугаар сард мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулж явууллаа. Судалгааг явуулахад ДЭМБ-ын Женев дахь төвийн багаас техник аргачлалын туслалцаа үзүүлсэн.

Үндэсний хэмжээнд хийгдсэн энэхүү судалгааны аргачлалыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Анагаах ухааны хяналтын Ёс зүйн хорооны хурлаар судалгаа явуулах зөвшөөрөл авсан.

Судалгааны тайланд орсон үзүүлэлтүүдийг улсын дүнгээр болон хот, хөдөөгийн түвшингээр гаргалаа.

### *Эсэн мэнд амьдрах эрх*

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхэд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах, насандаа тохирсон шим тэжээлтэй хоол хүнс хэрэглэх, ундны цэвэр усаар хангагдах, амь нас эрүүл мэндэд аюул учруулахгүй орчинд амьдрах эрхүүд ордог. Эсэн мэнд амьдрах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Амьд явах эрх” гэж, Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхэд амьд явах жам ёсны эрхтэй” хэмээн тус тус тодорхойлсон.

Өсвөр насныхны эсэн мэнд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар тодруулахын тулд хэрэгжиж буй стандартуудын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хүүхдээс асуулгын аргаар, багш нараас зорилтот бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулснаас гадна судлаачид тусгайлан бэлтгэсэн ажиглалтын хуудсыг ашиглан үнэлгээ хийсэн. Цугларсан мэдээлэлд тулгуурлан судалгааны үр дүнг дараах хүрээгээр гаргав. Үүнд:

1. Сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий үнэлгээ,
2. Сургуулийн гадаад орчны үнэлгээ,
3. Сургууль руу ирж, очих замын аюулгүй байдал,

4. Сургуулийн дотоод орчны үнэлгээ, Дотуур байрны аюулгүй байдал,Жендэр ба аюулгүй байдал,
5. Гамшгийн бэлэн байдал.

Суралцагчдын 73.1 хувь нь өнгөрсөн жилийн хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдаагүй гэж хариулжээ.

Хотын хүүхдүүдийн сургуульд ирж очих замдаа саад бэрхшээлтэй тулгарах байдал хөдөөгийн хүүхдүүдээс 10.5 хувиар илүү байна.

Ажиглалт судалгааны үр дүнгээр улсын хэмжээнд сургуулиудын эргэн тойронд (150 м хүртэлх газар) хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байна. Сургуулийн эргэн тойрны 150 м хүртэлх газарт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийг дүгнэхэд 60-аас доош хувьтай нь нийт сургуулиудын 17.6 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлтийг хот, хөдөөгийн сургуулиар нь тодруулбал хөдөөгийн сургуулийн хэрэгжилт хотынхоос 2 дахин муу буюу 21.9 хувь нь хангалтгүй байна.

Хотын хүүхдүүдийн 38.8 хувь нь сургуульд ирж, очихдоо ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог. Тэдгээрийн 18.4 хувь нь нийтийн тээврээр, 11.3 хувь нь хувийн унаагаар, 4.6 хувь нь таксигаар, 4.5 хувь нь сургуулийн автобусаар тус тус зорчиж байна. Хөдөөгийн сурагчдын 90.0 хувь, хотын сурагчдын 57.9 хувь нь сургуульдаа явганаар ирж, очдог.

Бэрхшээлийн төрлөөр харьцуулбал, автозамын түгжрэл (12.3 хувь), нохойноос айх айдас (9.4 хувь), гэрэлтүүлэг муу байдал (9.1 хувь), шороон замын хальтаргаатай байдал (8.0 хувь) зэрэг байв.

2021-2022 онд Монгол улсын хэмжээнд нийт 548 дотуур байранд 34,546[1] хүүхэд амьдарч байжээ. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 54.9 хувь нь дотуур байртай, 45.1 хувь нь дотуур байргүй байсан.

Хөдөөгийн дөрвөн сургууль тутмын нэг нь ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих усны эх үүсвэр байхгүй, зөөврийн цэвэршүүлсэн усыг тогтмол авч хэрэглэх төсөв зардлын хүрэлцээгүй байдал зэргээс шалтгаалсан цэвэр усны хүртээмжийн асуудалтай байна.

Сургууль дахь эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөний халуун усны хангамж 45.1 хувьтай, байна.

Судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын 80.4 хувь нь гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна. Гэвч сургуулийн төлөвлөлт, барилгын зураг, ойр орчмын барилга байгууламжийн хоорондын зай хэмжээ нь гамшгийн бэлэн байдлын шаардлагад нийцэхгүй байгаа нь ажиглалтын судалгаагаар гарсан.

### *Хөгжих эрх*

Хүүхдийн эрхийн тухай хуульд “хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил” гэж үзнэ хэмээн заасан.

1 Сурч боловсрох эрх: Дотуур байр үндэсний II зөвлөгөөн. БШУЯ. 2023 он

Хүүхдийн эрхийн конвенцод хүүхдийн хөгжих эрхийг онцлон анхаарч боловсрол эзэмших, чөлөөт цагаа өнгөрүүлэх, соёл урлаг, урлан бүтээх үйл ажиллагаанд хамрагдах эрхийг хүүхэд бүрд тэгш эдлүүлэх үүргийг гишүүн улс орнууддаа өгсөн байдаг.

Хүүхдийн хөгжих эрхийг хангахад боловсролын байгууллагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны засаг дарга нар, хуулийн этгээд, эцэг, эх, асран хамгаалагч хэрхэн оролцохыг Хүүхдийн эрхийн хуулиар тогтоожээ.

Сургуулийн орчинд спорт, урлагаар хичээллэх орон зай, анги танхим, зай талбайн хүрэлцээгүй байдал нь  хичээлээс гадуур хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн 40.0 хувьд нөлөөлжээ.

Хүүхдүүдийн 31.0 хувь нь тэдний сурч буй сургууль спорт тоглоомын талбайгүй, харин 31.5 хувьд нь сургуулийн гадаа спортоор хичээллэх, тоглох боломж хязгаарлагдмал бол 15.3 хувь нь тоглоомын талбайд тоглуулдаггүй гэсэн хариултуудыг өгчээ. Гадаа тоглох сонирхолгүй, завгүй хүүхдүүд нийлээд 14.8 хувийг эзэлж байна.

Нийгмийн сүлжээ, интернэтээс өсвөр насныхны  60.3 хувь нь өөрт хэрэгтэй мэдээллээ авч байгаа бөгөөд хотын хүүхдүүд энэ талаар хөдөөгийн хүүхдүүдээс 13.0 хувиар өндөр байна.

Хүүхдүүдийн 35.6 хувь нь зуны амралтыг гэртээ дуртай зүйлээ хийж амарсан бол 23.6 хувь нь мал маллах, цагаан идээ боловсруулах байдлаар өнгөрөөсөн байна. Өрхийн үйлдвэрлэлд оролцох нь уламжлал болсон бөгөөд ихэвчлэн цалин хөлсгүй ажил юм. Энэ төрлийн ажилд хөдөөгийн таван хүүхэд тутмын хоёр (43.3 хувь), хотын 5 хүүхэд тутмын 1 (17.9 хувь) нь оролцсон байна.

### *Оролцох эрх*

Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, бүлэг, хамтлаг, клубийн үйл ажиллагаанд сүүлийн 12 сарын хугацаанд оролцсон эсэх талаар тодруулахад хүүхдүүдийн 60.0 орчим хувь нь “Үгүй” гэж хариулжээ.

Хүүхэд өөртэй нь хамааралтай асуудлаар санал бодлоо илэрхийлж шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжоо бүрэн эдэлж чадахгүй байгаа нь сум, аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас хүүхдүүдийн өгсөн саналын дагуу хүүхэд, залууст зориулсан ямар нэгэн төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил хийх шийдвэр гарсан талаар дийлэнх нь сонсоогүй, мэдэхгүй гэсэн хариулт өгснөөс харагдаж байна.

Өсвөр насныхны сайн дурын ажилд оролцсон байдал 45.3 хувьтай байна. Хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс сайн дурын ажилд оролцох нь 9.0 хувиар өндөр байна.

Сүүлийн жилүүдэд сурагчдын дунд сайн дурын ажилд хамт олноороо оролцох сонирхлын бүлгүүд бий болж, төрөл бүрийн сайн үйлсийн аян өрнүүлж байгааг багш нар ярилцлагын үеэр сайшаан дурдсан. Сайн дурын

болон хүмүүнлэгийн үйл ажиллагаануудын жишээ татахдаа өсвөрийн улаан загалмай, интеракт клуб, зорилтот бүлгийн хүүхдүүдэд тусламж дэмжлэгийн аян өрнүүлдэг талаар багш нар дурдсан.

### *Хамгаалуулах эрх*

Өсвөр насанд шилжиж буй хүүхдүүдийн хувьд бэлгийн бойжилт, гэр бүл, сургуулийн орчны өөрчлөлт нь тэдэнд өсөлт дэвшлийг авчрахаас гадна шинэ эрсдэлийг дагуулдаг. Ялангуяа, энэ хугацаанд эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс хайр халамж бага, хараа хяналт сул, түр болон урт хугацаагаар эцэг, эхээсээ хол амьдрах нь хүүхдүүдэд учирч болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлдэг. Хүүхдийн хаана хэнтэй амьдарч байгаагаас гадна тэдний нас, хүйс, хот, хөдөөгийн ялгаа, сургууль, дотуур байрны орчны аюулгүй байдал, хамгааллын үйлчилгээний хүртээмж зэрэг нь хүүхдийг эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс юм. Эдгээр нь эрсдэлт болон хамгааллын хүчин зүйлс гэж хуваагддаг. Эрсдэлийг бууруулж, хамгааллын хүчин зүйлсийг нэмэгдүүлэхэд хууль эрх зүйн зохицуулалт чухал ач холбогдолтой. Өсвөр насны хүүхдийн хамгаалагдах эрхэд хамаарах хууль эрх зүйн заалтуудаас дурдвал:

- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1-д "Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй";
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.6-д "Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодын болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно";
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.1-д суралцагч нь "аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид, ээлтэй, аюулгүй, хамгаалагдсан орчинд суралцах" эрхтэйг заасан бөгөөд 13.1.3-т бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй байх, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх үүрэгтэйг тодорхойлсон байна;
- Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.8-д зааснаар сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, боловсролын сургалтын байгууллагыг арга зүй, зохицуулалтаар хангах үүргийг аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэст хариуцуулсан.

Хүчирхийлэлд өртсөн тохиолдолд нэн тэргүүнд хандах хүний хувьд эрэгтэй сурагчдын 33.1 хувь нь сургуулийн нийгмийн ажилтан, эмэгтэй сурагчдын 39.4 хувь нь эцэг, эхдээ мэдэгдэнэ гэжээ. Эмэгтэй сурагчдын 4.8

хувь цагдаад хандахыг илүүд үзэж, харин хүүхдийн тусламжийн 108 утсанд хандана гэсэн сурагчдын хувь маш бага байна. Сэтгэл зүйчид хандана гэсэн эмэгтэй сурагчдын хувь (12.3 хувь) эрэгтэй хүүхдүүдээс (6.5 хувь) ойролцоогоор 2 дахин илүү байна.

Хүүхдэд үе тэнгийнхний дээрэлхэлт, бие махбодын шийтгэлээс ангид байх эрхийн тухай таниулах нь чухал байна. 4 хүүхэд тутмын 1 нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл зайлшгүй хэрэгцээтэй гэдэгтээ санал нийлж байгаа нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх соёл өсвөр насныхны дунд илэрч байна. Эрэгтэй сурагчдын хувьд 33.6 хувь нь охидын 19.0 хувь нь бие махбодын шийтгэлийг зайлшгүй хэрэгцээтэй гэж үзжээ. Хөдөөгийн хүүхдүүд ийм төрлийн шийтгэлийг зөв гэж үзэх нь хотын үе тэнгийнхнээсээ 7.6 хувиар илүү байна.

Цахим дээрэлхэлтэд өртөх байдлын хувьд эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдээс 7.4 хувиар илүү байна. Огт танихгүй хүнтэйгээ 2 хүүхэд тутмын 1 нь интернэт орчинд харилцаж байсныг нь судалгааны үр дүн харуулав. Мөн хүүхдүүдийн 26.0 хувь нь цахим орчинд танилцсан хүнтэйгээ биечлэн уулзжээ. Эмэгтэй сурагчдын хувьд интернэт орчинд танилцсан хүнтэйгээ биечлэн уулзсан хувь эрэгтэй сурагчдаас 8.9 хувиар илүү байна.

### *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд сургуульд хүрж очих зам, хаалга, шат, бие засах газар, анги танхим цогцоороо хүртээмжтэй, аюулгүй байгаа нөхцөлд хүүхдүүд сурах эрхээ бүрэн эдэлж чадна. Мөн тэдэнд хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогт нийцсэн сургалтын хөтөлбөр, тусгай хэрэгцээнд нь нийцсэн сургах арга барил эзэмшсэн багш, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжийг нь дэмжсэн орчин хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамруулах сургалтын үр нөлөөг хүртэхэд ялгаварлан гадуурхалт, бүх төрлийн хүчирхийллээс ангид орчин чухал үүрэгтэй. Хамт суралцагч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдүүдийн зүгээс ялгаварлан гадуурхах, үл хайхрах, дээрэлхэх, сэтгэл санааны хүчирхийлэлд өртүүлэх эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй байх, сурах үйл ажиллагаанд нь саад учруулахгүй байх нь чухал ач холбогдолтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагын талаарх хүүхдүүдийн ойлголт хангалтгүй байгаа нь “Танай сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжтой эсэх" гэдэг асуултад 4 хүүхэд тутмын 1-нь “мэдэхгүй байна" гэсэн хариулт сонгосноос харагдаж байна. Хөдөөгийн хүүхдүүдийн 28.0 хувь нь энэ талаар мэдлэг ойлголтгүй байгаагаа хэлжээ. Үүнийг “энгийн хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хамт суралцах ойлголт, мэдээлэл багатай байгаа нь сургалтад бэрхшээл учруулж байна“ гэсэн багш нарын яриа нотолж байв. Мөн багш нарын дунд ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах, хөгжих орчин хүртээмжгүй гэж дүгнэсэн.

Хүртээмжийг нь сайжруулах боломжгүй, хуучирсан барилгатай, зай талбайн хүрэлцээгүй байдал, төсөв хөрөнгийн дутмаг байдал,тэдэнд зориулсан хичээлээс гадуур хөгжлийн хөтөлбөр гараагүй зэрэг шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд  сургууль, дотуур байрны гадаад болон дотоод орчин ээлтэй байж чадахгүй байна. Хэдийгээр хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй ердийн сургуульд суралцахад дэмжлэг болох онцлог хэрэгцээ шаардлагыг сайн мэдэхгүй байгаа ч тэднийг дэмжиж туслахаа илэрхийлсэн. Тухайлбал, хүүхдүүдийн 66.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өөрийнхөө чадахаар туслахыг бодно гэсэн байна. Энэ хариултыг сонгосон эмэгтэй сурагчдын хувь эрэгтэй сурагчдаас 2.9 хувиар илүү байна.

## *Монгол улсын талаар үндсэн мэдээлэл*

Монгол Улс Төв Азийн зүүн хойд хэсэгт нийт 1564.1 мянган ам дөрвөлжин километр газар нутгийг эзлэн орших бөгөөд хойд хэсгээрээ Оросын Холбооны улс (ОХУ), өмнө талаараа Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-тай хиллэдэг. Улсын хилийн нийт урт 8161.9 км, үүнээс ОХУ-тай хиллэх хилийн урт 3485 км, БНХАУ-тай хиллэх хилийн урт 4676.9 км. Монгол улс дэлхийд нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ 17-д ордог, далайн түвшнээс дээш дунджаар 1580 м өндөрт өргөгдсөн, далайд гарцгүй орон юм. Нутгийн баруун, хойд хэсэгт нь уулархаг, ойн бүс, Зүүн хэсэгт тал хээрийн бүс, Өмнөд хэсэгт говийн бүс зонхилдог (Зураг 1).

*Зураг 1. Монгол Улсын засаг захиргааны нэгж, аймаг, нийслэлээр*




Хавар, зун, намар, өвөл гэсэн жилийн 4 улиралтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын дундаж температур зундаа (6-8 дугаар сард) +10˚С -аас +25˚С, өвөлдөө (12-2 дугаар сард) -12˚С-аас -36˚С орчимд хэлбэлздэг боловч агаарын үнэмлэхүй их температур +45˚С, агаарын үнэмлэхүй бага температур -55˚С юм.

Монгол Улс нь засаг захиргааны нэгжийн хувьд аймаг, нийслэлд хуваагдана. Аймаг нь дотроо сум, баг, нийслэл нь дүүрэг, хороо гэсэн дэд хэсэгт хуваагдаж зохион байгуулагдана. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот (Зураг 1) юм. Өнөөгийн байдлаар Монгол Улс 21 аймаг, 330 сум, 1820 гаруй баг, нийслэл хот, 9 дүүрэг, 204 хороотой.

Монгол Улсын төрийн албан ёсны хэл нь монгол хэл бөгөөд Монголчууд үндэсний бичиг, соёл, эртний түүхт өвөрмөц иргэншлээ хадгалж үлдсэн ард түмэн юм. Хүн амын олонх нь буддын шашин шүтдэг. 1990-ээд оноос эхлэн шашин шүтэх эрх чөлөө нээлттэй болсноор монголчууд буддын шашнаас гадна христ, исламын шашин зэрэг бусад төрлийн шүтлэгийн хэлбэр, урсгалыг шүтэх болов.

Аж ахуйн хувьд нүүдлийн мал аж ахуйг одоог хүртэл эрхэлдэг. Харин цаг агаар болон байгаль, газар нутгийн нөхцөл байдлаас хамааран эрт үеэс газар тариалан, худалдаа, гар урлалыг хавсарга байдлаар эрхэлсээр ирсэн бөгөөд энэ нь үндэсний уламжлал, соёл иргэншлийн илэрхийлэл, төлөвийг тодорхойлогч хүчин зүйл болдог.

### *Хүн амын тоо, өөрчлөлт*

Монголын Улсын хүн амын өсөлт XX зууны дунд үе хүртэл маш удаан өсөж байв. Хүн амын өсөлт бага байхад нөлөөлсөн гол хүчин зүйлс нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил буурай, эрүүлийг хамгаалах тогтолцоо бүрэлдэн тогтоогүй байсантай холбоотойгоор хүн амын эрүүл мэндийн байдал сул дорой, боловсролын ерөнхий түвшин маш доогуур байсан явдал юм. Гэвч өнгөрсөн зуунд Монголын хүн амын тоо 3.7 дахин өссөн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсын хүн амын өсөлтийг 3 үе шатаар дараах байдлаар авч үздэг:

- Удаан буюу зогсонги өсөлтийн үе 1950-иад он хүртэл,
- Өсөлт эрчимтэй нэмэгдэж байсан үе 1950-1980 оны дунд үе,
- Хүн амын өсөлтийн аажим бууралтын үе буюу 1980-аад оны дундаас хойших үе гэж хуваан авч үзэж болно (Хүснэгт 1).

1918, 1956 онуудад хүн амын тооллого явагдсан бөгөөд нийт хүн ам 647.5 мянгаас 845.5 мянга болж нэмэгдсэн ч энэ хугацаанд жилд дунджаар 1.0 хүрэхгүй хувиар өсөж байлаа. 1940 оноос хойших нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн томоохон шинэчлэл, бүтээн байгуулалт, хүний хөгжлийг хангах талаар явуулсан бодлого, үйл ажиллагааны үр дүнд хүн амын амьжиргааны түвшин бодитой сайжирч орчин үеийн эрүүл мэндийн үйлчилгээний тогтолцоо үүсэж хөгжив. Эдгээр өөрчлөлтийн дунд төрөлт нэмэгдэн, нас баралт буурснаар хүн амын тоо хурдацтай өсөж, 1956-1980-аад оны дунд үе хүртэл жилд дунджаар 1.0-2.9 хувиар өсөж байлаа.

*Хүснэгт 1. Монгол Улсын хүн ам зүйн үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт | 1989 | 2000 | 2010 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|
| Нийт хүн ам (мянгаар) | 2 044 | 2 374 | 2 754 | 3 296 | 3409 | 3458 |
| Эрэгтэй (хувиар) | 49.9 | 49.6 | 49.5 | 49.1 | 49.1 | 49.1 |
| Эмэгтэй (хувиар) | 50.1 | 50.4 | 50.5 | 50.9 | 50.9 | 50.9 |
| 0-4 нас (хувиар) | 15.9 | 10.4 | 10.6 | 11.7 | 11.7 | 10.6 |
| 5-14 нас (хувиар) | 26.0 | 25.4 | 16.7 | 19.8 | 22.7 | 21.4 |
| 15-64 нас (хувиар) | 54.1 | 60.8 | 69.0 | 64.4 | 63.4 | 63.4 |
| 65 дээш (хувиар) | 4.0 | 3.5 | 3.7 | 4.1 | 4.5 | 4.7 |
| 15-49 эмэгтэйчүүд (хувиар) | 23.5 | 27.2 | 30.1 | 24.8 | 24.2 | 25.3 |
| Хүйсийн харьцаа (хувиар) | 99.7 | 98.5 | 98.1 | 96.6 | 96.4 | 96.3 |
| Хүн ам зүйн ачаалал | 84.8 | 64.6 | 45.4 | 56.6 | 57.7 | 57.8 |
| Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь | 2.5 | 1.4 | 1.5 | 2.2 | 1.6 | 1.4 |

Монголын хүн ам 1918-2020 оны тооллогын хооронд ойролцоогоор 5 дахин нэмэгдсэн. Нийгэм, эдийн засгийн өөрчлөн байгуулалт, тогтолцооны хувьд эрс шинэчлэл хийсэн 1990-ээд оны ардчилсан хувьсгалын шууд нөлөөгөөр Монгол Улс бодитой хүндрэл, бэрхшээлийг туулсан. Төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн явц нь хүн ам зүйн үзэгдэлд шууд нөлөөлж, хүн амын өсөлтийн хурд эрчимтэй саарсан.

Хүн амын өсөлтийн хурд буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл бол төрөлтийн түвшний бууралт юм. 1990 онд 1000 хүн ам тутамд 35.3 төрөлт ногдож байсан бол 2005 онд 17.8 болж, хамгийн доод түвшинд хүрч байв. Энэ хугацаанд нөхөн үржихүйн насны нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлж байгаа хүүхдийн дундаж тоо 1990 онд 4.5 байснаа 2005 онд хамгийн бага түвшин буюу 1.9 болж, даруй 2.4 дахин буурсан. Харин өнөө цагт төрөлт нэмэгдэж, 2022 оны байдлаар 2.6 хүрсэн. Нас баралт мөн сүүлийн 40 орчим жилд мэдэгдэхүйц буурсан бөгөөд 1000 хүн амд ногдох нас баралт 1970 онд 12.3 байсан бол 1990 онд 8.5, харин 2020 онд 5.6 болж буурав. Улс орны төрөөс хүн амын төрөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, тухайн үеийн улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт нөлөөлсөн гэж дүгнэж болно.

Монгол Улсын хүн амын тоо 2023 оны жилийн эхний байдлаар 3,458[2] мянгад хүрч, 2022 онтой харьцуулахад 48 мянга буюу 1.4 хувиар өсжээ. Нийт хүн амын 49.1 хувь эрэгтэйчүүд, 50.9 хувь эмэгтэйчүүд эзэлж байна. Монгол Улсын хүн ам харьцангуй залуу бүтэцтэй бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь (62.5 хувь) их байна.

2 https://www.1212.mn/mn Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Монгол Улсад оршин суугаа хүн амын тоо

# 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

## *1.1. Үндэслэл*

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцод 1990 онд нэгдэн орж, конвенцын үзэл санаа, зарчимд нийцүүлэн Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталж, 2016 онд хүүхдийн аюулгүй байдал, хамгааллын орчныг сайжруулж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн тулд уг хуулийг Хүүхдийн Эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай гэх бие даасан хоёр хууль болгон баталж, хүүхэд бүрийг аливаа төрлийн хүчирхийллээс ангид байх эрхийг баталгаажуулсан. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийн хувьд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас “ Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж 18-аас доош насны хүүхдүүдийн эсрэг үйлдэгдсэн бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл болон үл хайхрах байдал” хэмээн заасан тодорхойлолтын үзэл санаа Хүүхэд хамгааллын хуулийн үзэл баримтлалын цөм нь болж орсон.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн эрхийг эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох гэсэн 4 бүлэгт хувааж эдгээр эрхээ хүүхэд бүр эдлэхэд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хүлээх чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоогоор дамжуулан хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх зохицуулалтууд баталгаажсан. 2023 онд шинэчлэгдэн батлагдсан Боловсролын багц хуулиудад Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаас эшилж, хүүхдийн бүхий л эрхийг сургууль, дотуур байрны орчинд хангах заалтууд орсон.

- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1-д “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.6-д “Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодын болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно”;
- Боловсролын ерөнхий хуулийн 13.2.5-д “суралцагчаа хүндэтгэх, бие даасан байр сууръ, үзэл бодол, онцлог байдлыг нь хүлээн зөвшөөрч зөв хандлагаар чиглүүлж, хөгжүүлэн дэмжих”, 13.2.6-д “хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах, суралцагчийг ялгаварлан гадуурхсан аливаа үйлдэл гаргахгүй байх, суралцах арга барилыг дэмжих”;

ХЭК-ийн гишүүн орнууд хүүхдийн эрхийн хэрэгжилт, хамгааллын хүчин зүйлийн талаар тогтмол судалгаа хийж, хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьсан бодлого шийдэл гаргаж, тулгарч буй асуудал, бэрхшээлийг хүүхдэд ээлтэйгээр шийдвэрлэх үүрэг хүлээдэг. Монгол Улсад хүүхдийн эрх,

хамгааллын ямар асуудлууд тулгарч байгааг захиргааны мэдээлэл болон судалгааны үр дүнгээс гарсан дараах тоо баримтаас харж болно. Тухайлбал,

- 2022 оны байдлаар нийт 1,295 мянга буюу нийт хүн амын 37.5[3] хувь 0-18 насныхан эзэлж байна. Эдгээрээс бүтэн өнчин 2911, хагас өнчин 36363 хүүхэд байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй 115115[4] хүн бүртгэгдсэнээс 10.3 хувийг буюу 11818 нь 18 хүртэлх насныхан эзэлж байна.
- 2022 оны байдлаар хөдөлмөр эрхэлдэг 533, хурдан морины уралдаанч хүүхэд 6749, хараа хяналтгүй 53 хүүхэд[5] тус тус бүртгэгдсэн байна.
- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний хүрээнд 2022 онд нийт 111776[6] дуудлага ирснээс зорилтот 65959 байжээ. Эдгээрээс ангиллын хувьд хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэд хамгааллын 16300 тохиолдол бүртгэгдсэн.
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай 446034, эрсдэлт нөхцөлд амьдарч буй 14207, асрамж, хүнсний эрхийн бичигт хамрагдаж буй 76063 хүүхэд[7] байна.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн төвөөр 2022 онд үйлчлүүлсэн 3226[8] хүүхэд.
- Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 1540[9], гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд 2014 байна.
- Зам тээврийн ослын улмаас нийт 1041 хүн хохирсны 3.5[10] хувийг хүүхдүүд эзэлж байна.

Нийгэмд буй эдгээр үзэгдлийн цар хүрээ, хэлбэрийг олон улсад харьцуулагдахуйц арга, аргачлалын дагуу судлах хэрэгцээ шаардлагыг үндэслэн тус судалгааг зохион байгуулав.

3 https://www.1212.mn/ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Монгол Улсын хүн амын тоо

4 https://www.1212.mn/ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо

5 Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. 2022 оны жилийн эцсийн мэдээ

6 Цагдаагийн ерөнхий газрын 108-утас дуудлагын мэдээлэл

7 Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны жилийн эцсийн мэдээ

8 Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. 2022 онд үндэсний хэмжээнд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоон мэдээ

9 https://information.police.gov.mn/ Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын статистик тоон мэдээлэл. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг

10 https://www.1212.mn/ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Хохирсон хүн

## 1.2. Судалгааны зорилго

Судалгааны зорилго нь өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, эрх, хамгааллын өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн арга аргачлалын дагуу цогц мэдээллийг цуглуулах, боловсруулах, бодлого, хөтөлбөрийн үр дүнг хэмжих, цаашдын суурь мэдээллийг бий болгоход оршино.

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Өсвөр насны хүүхдийн эрүүл мэнд, эрхийг хангах, хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны нөлөөллийг тодруулах;
- Хүүхдийн эрүүл мэндийн зан үйл, эрх, түүнтэй холбоотой асуудлаар тоон мэдээллийг бий болгох, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрийн суурь мэдээллийн баазыг бүрдүүлэх;
- Тогтвортой хөгжлийн 4 болон 16.2 зорилтуудын үзүүлэлтийг тооцож гаргах;
- Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын эрүүл мэнд, хүүхдийн эрх, хамгааллыг сайжруулахын тулд цаашид авах бодлогын шийдлийг үндэслэл болохуйц саналыг гаргах.

## 1.3. Хүлээгдэж буй үр дүн

Судалгаагаар хүүхдийн эрх, түүнтэй холбоотой асуудлаар тоон мэдээллийг бий болгох, түүнд нөлөөлөхүйц хүчин зүйлсийн цар хүрээ, хэлбэрийг тодорхойлох, хүүхэд хамгааллын чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний суурь мэдээллийн баазыг бүрдүүлэх ач холбогдолтой юм. Мөн Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хянах мэдээллийн санг өргөтгөж, олон улсад монгол хүүхдийн эрхийн нөхцөл байдлын мэдээллээр баяжилт хийгдэнэ.

## 1.4. Судлагдсан байдал

Хүүхдийн эрүүл мэнд, эрх, хамгааллын асуудлаар сүүлийн 10 жилийн хугацаанд манай оронд дараах судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байна.

*Дэлхий дахины сургуульд суурилсан Хүүхдийн эрүүл мэндийн судалгаа - 2013 он*

ЭМЯ, ДЭМБ-аас Монгол Улсын хэмжээнд 13-17 насны хүүхдүүдээс тамхи, согтууруулах ундааны хэрэглээ, үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл зэрэг 10 модуль асуултын хүрээнд хүүхдийн амьдарч буй нөхцөл, зан үйл, аюулгүй байдлыг судалсан.

*Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа -2014 он*

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас тус судалгааг Нийслэлийн хэмжээнд 11-17 насны хүүхдүүд, тэдний эцэг, эхчүүдийн хүрээнд хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлыг бие махбод, сэтгэл зүйн, бэлгийн хүчирхийллийн хэлбэрүүдээр ангилан судалсан.

*Хүүхдийн хамтарсан багийн өнөөгийн байдал – 2015 он*

Японы Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлсэн судалгааны дүнд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн зонхилох хувь нь амьдарч буй орчин, тэр дундаа сургуулийг "айж эмээх зүйлтэй, айдастай орчин" хэмээн үзжээ.

*Хүүхдийн эрх ба хамгаалал судалгаа – 2017 он*

Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс олон улсын байгууллага хамтран хүүхдийн эрхийн зөрчил, түүний шалтгаан, хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилготой хэрэгжүүлсэн. 12-18 насны хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчид болон хамтарсан багийн гишүүдийг судалгаанд хамруулжээ.. Судалгааны дүнд 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг хүчирхийлэлд өртсөн ба энэ нь гэр бүл, сургуулийн орчинд хамгийн их гардаг талаар дүгнэжээ. Хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгчийн хувьд дээд ангийн хүүхэд нэгдүгээрт эрэмбэлэгджээ.

*Өсвөр үеийнхний дуу хоолой -2017 он*

Японы Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлсэн энэхүү судалгааны хувьд хүүхдийн аюулгүй байх эрхийн асуудлыг хөндсөн. Энэ хүрээнд хүүхдүүдийн өөрт нь оногдсон эрхийн талаарх мэдлэг, гэр сургууль орчны талаар үнэлүүлжээ.

*Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн судалгаа -2018 он*

БСШУЯ-аас 2-21 насны хүүхэд, залуучуудаас тэдгээрийн нас бүрийн бие бялдар, танин мэдэхүй болон нийгэмшлийн хөгжлийн онцлогийг илрүүлжээ.

*Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа – 2018 он*

ҮСХ-оос эрхлэн гаргадаг тус судалгааны "Хүүхдийн хүмүүжил" бүлэгт 1-14 насны хүүхдээ хүмүүжүүлэхдээ хэрэглэж буй бие махбод болон сэтгэл санааны хүчирхийллийн талаар судалжээ. Судалгаагаар манай улсад хүүхдүүдийн 33.2 хувь нь бие махбодын хүчирхийлэлд, 40.4 хувь нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж буйг тогтоосон байна.

*Сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, хүчирхийллийг зогсоох нь – 2019 он*

НҮББШУСБ-аас нийт 144 улсыг хамруулсан мэдээллийг нэгтгэн гаргасан энэ судалгаагаар Монгол Улсад 12 сарын хугацаанд сургуулийн орчин дахь дээрэнгүйлэл, хүчирхийлэлд өртсөн нийт хүүхдүүдийн 43.8 хувь нь зодоон хийсэн бол 30.0 хувь нь бие махбодын халдлагад өртсөн гэх дүгнэлт гарсан.

*Хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн асуудлын судалгаа – 2021 он*

Хөл хорио тогтоосонтой холбоотойгоор хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгын хүрээнд хүүхэд, эцэг, эх, багш

нарт тулгамдсан асуудлыг илрүүлж, хүүхдийн сэтгэлзүйд гарч болзошгүй эрсдэлийг НҮБ-ын Хүүхдийн Сангаас судалжээ.

*Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал – 2021 он*

Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны өнөөгийн байдлыг эрх зүйн орчин, үйлчилгээ, чадавх, хамтын ажиллагаа, хариуцлагатай байдал, үйлчилгээ, хүүхдийн оролцоо гэсэн сэдвүүдийн хүрээнд судлан нөхцөл байдлын үнэлжээ.

*Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн үнэлгээ – 2021 он*

ХНХЯ-ны захиалгаар Корам Интернейшнл байгууллагаас Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн бөгөөд тус ажлын хүрээнд хүүхэд хамгааллын тогтолцоотой холбоотой бодлого, хууль, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд хууль эрхзүйн давхцалыг арилгах, хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлох, санхүүжилт, хүний нөөцийн манлайллын талаар сайжруулах, цаашдын зөвлөмжийг боловсруулсан.

## *1.5. Судалгааны арга зүй*

Судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан гүйцэтгэв. Үүнд:

- Суралцагч буюу ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 13-17 насны хүүхдээс тоон судалгаа,
- Боловсролын байгууллагын төлөөлөл буюу багш нарын хүрээнд фокус бүлгийн ярилцлага,
- Сургуулийн орчинд судалгааны бэлтгэгдсэн баг батлагдсан маягтийн дагуу үнэлж, хоёрдогч мэдээлэл боловсруулалт буюу холбогдох хууль эрх зүйн акт, баримт бичгийн шинжилгээг тус тус хийлээ.

## *1.6. Түүврийн зохиомж ба судалгааны хамрах хүрээ*

### Хамрах хүрээ

Монгол Улсын нийт 13-17 насны ерөнхий боловсролын сургуульд суралцагчид судалгааны эх олонлогийг бүрдүүлсэн бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд 773 ерөнхий боловсролын сургуульд 13-17 насны нийт 237521 хүүхэд суралцаж байсан. Уг эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн сурагчдын эрх, хамгааллын нөхцөл байдлыг үнэлэхийг зорьсон юм.

## *Зураг 1.1. Судалгааны түүврийн хүрээ “Хотын сургуулиуд”*




## *Зураг 1.2. Судалгааны түүврийн хүрээ “Хөдөөгийн сургуулиуд”*



## Түүврийн нэгж

Судалгааны мэдээлэл цуглуулалтын анхан шатны түүврийн нэгж нь 13-17 насны хүүхэд байв.

## Судалгааны үр дүнг тархаах түвшин

Судалгааны үр дүнг үндэсний болон болон хот, хөдөөг төлөөлөхүйц байдлаар боловсруулах зорилт тавигдсан. Аймгийн болон бүсийн түвшинд үр дүнг боловсруулах зорилт тавигдаагүй бөгөөд нарийвчлалын түвшин нь зөвхөн хот, хөдөөгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц байхаар тооцсон.

## Түүврийн хэмжээг тодорхойлох

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томьёоллын дагуу тооцсон. Үүнд:

$$n=\frac{Z^2\times P_0\times(1-P_0)}{e^2}\times deff\times rr$$

(1)

z=хүсэж буй ач холбогдлын түвшинг тодорхойлсон статистик утга
$P_0$=түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
e=алдааны хязгаар
*deff*= тухайн дизайны үр ашигтай байдал /design effect/
*rr*=асуулгад хариулахгүй байх байдлаар засварлагч

Дээрх томьёоллын дагуу түүврийн хэмжээг тодорхойлохын тулд эхлээд өгөгдсөн хувьсагчдын утгыг тодорхойлно. Үүнд:

z-95.0 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга 1.96

$P_0$-түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Өмнө нь ижил төрлийн судалгаа явж байгаагүй үед болон тодорхой төсөөлөл байхгүй үед =0.50)

e-таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (Бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдаа 4.8 хувь буюу абсолют алдаа **0.012**)

*deff*-тооцох боломжгүй бөгөөд бид **2.0**-той тэнцүү байна гэж таамагласан.

*rr*-судалгаанд 10 хүн тутмын нэг буюу 10 хувь нь ямар нэгэн шалтгаанаар хариулахгүй байна гэж үзсэн. Тэгвэл rr=**1.1** болно.

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг тооцоход ойролцоогоор 3705 болж байна. Түүврийн хэмжээний итгэх интервал (ИХ) 95.0 хувь, статистикийн илрэх магадлал 80.0 хувь, статистик, α=0.05-аар тооцоолж нийт 44 сургууль, 3200 сурагчдыг хамруулахад төлөөлөх чадвартай магадлалт түүвэр болно. Сургууль болон сурагчдын судалгаанд хамрагдалтын хувийг 90 хувиар тооцвол энэхүү судалгаанд нийт 50 сургуулийн 3750 хүүхдийг сонгож хамруулахаар төлөвлөсөн.

## Түүврийн хуваарилалт

Судалгааны үр дүнг үндэсний түвшинд болон хот, хөдөөгийн түвшинд тооцож гаргах талаар өмнө дурдсан. Судалгааны үр дүнгийн нарийвчлалыг хангахын тулд аймгуудыг байршлаас нь хамааруулан бүлэглэж хот, хөдөөгийн сурагчдын тооноос хамааруулан пропорциональ аргаар хуваарилсан (Хүснэгт 1.1).

*Хүснэгт 1.1. Судалгаанд хамрагдсан ТАШН, бүс, аймгаар*

| | Сонгогдсон нэгжийн тоо | Сурагчдын тоо |
|---|---|---|
| Ховд, Увс, Баян-Өлгий | 6 | 450 |
| Архангай, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай | 7 | 525 |
| Төв, Сэлэнгэ, Хөвсгөл | 5 | 375 |
| Дархан-Уул, Дорнод,Сүхбаатар | 3 | 225 |
| Дорноговь, Өмнөговь | 4 | 300 |
| Ховд | 2 | 150 |
| Улаанбаатар | 24 | 1450 |
| **Нийт** | **51** | **3475** |

Судалгаанд нийт 51 ТАШН-ийг судалгаанд хамруулсан бөгөөд нэг ТАШН-ээс 75 сурагчийг түүврийн хоёр дах шатанд сонгох тул түүврийн хэмжээг 3475 болгон тэгшитгэсэн.

## Түүврийн үе шат

Судалгаанд оролцох сурагчдыг энгийн санамсаргүй 2 шатат бүлгийн түүврийн аргыг ашиглан сонгоно. Нэгдүгээр шатанд судалгаанд хамрагдах сургуулиудыг ДЭМБ-ын Төв байгууллагын түүврийн асуудал эрхэлсэн баг түүврийн стандарт аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Харин Хоёрдугаар шатны түүвэрлэлт буюу сонгогдсон сургуулиудаас судалгаанд оролцох ангийг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгож сурагчдыг хамруулсан.

Түүвэр хийх процесс үндсэн 2 үе шаттай бөгөөд судалгаанд оролцох сурагчдыг энгийн санамсаргүй 2 шатат кластер түүврийн аргаар сонгосон. Нэгдүгээр шатанд судалгаанд хамрагдах сургуулиудыг жагсааж 51 ТАШН-ийг буюу 51 сургуулийг пропорциональ хуваарилалтын аргаар ДЭМБ-ын түүврийн асуудал эрхэлсэн тусгай баг хуваарилсан. Харин Хоёрдугаар шатны түүвэрлэлтэд сонгогдсон сургуулиудаас судалгаанд оролцох хүүхдийг сургуулийн бүлэг, хүүхдийн тоонд үндэслэн сонгосон. Сонгогдсон хүүхдүүдийн асран хамгаалагч нарт урьдчилсан мэдээллийн хуудсыг сургуулиар дамжуулан хүргэхээс гадна, зөвшөөрлийн хуудас явуулсан. Зөвшөөрлөө судалгаанд орохын өмнө судалгааны багт өгсөн хүүхдүүдэд асуулгыг танилцуулж, хэрхэн нөхөхийг тайлбарласны дараа сурагчдыг судалгаанд хамруулсан.

### Түүврийн жинлэлт

Үр дүнгийн тооцоо хийх, дүн шинжилгээ боловсруулахад түүврийн жинг тооцож ашиглав. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай байв. Үүнд:

- Кластерийн тоо;
- Сонгогдсон кластерын сурагчдын тоо;
- Сонгогдсон сурагчдаас судалгаанд хамрагдах боломжтой сурагчдын тоо.

Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцсон.

Нэгдүгээр шатны түүврийн жин:

$$W_{1k}=\frac{A_k}{A_{ks}}$$

$A_k$=k дугаар бүлгийн сурагчдын тоо

$A_{ks}$=k дугаар бүлгээс сонгогдсон s ширхэг кластерийн сурагчдын тоо

Хоёрдугаар шатны түүврийн жин:

$$W_{2kj}=\frac{M_{kj}}{m_{kj}}$$

$M_{kj}$=k бүлгийн j кластерийн сурагчдын тоо

$m_{kj}$=k бүлгийн j кластерийн судалгаанд хамрагдсан сурагчдын тоо

Сурагчдын түүврийн жин дээрх 2 жингийн үржвэр байна:

$$W_{kj}=\frac{A_k}{A_{ks}} \times \frac{M_{kj}}{m_{kj}}$$

### *1.7. Судалгааны төлөвлөлт, зохион байгуулалт*

Тус судалгааг НҮБ-ын Хүүхдийн сан болон ДЭМБ-ын техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн зохион байгуулав.

Эдгээр байгууллагууд нь хамтдаа тоон болон чанарын судалгааны асуулга, үнэлгээний маягтуудыг боловсруулж, түүврийг зохиомжлон, мэдээлэл цуглуулах, мэдээллийг боловсруулах, үр дүн гаргах, нэгдсэн тайлан бичих, тархаах зэрэг судалгааны бүхий л үе шатны ажлыг удирдан хэрэгжүүлэв. Үүнд:

I. Бэлтгэл ажлын хүрээнд:

- Судалгааны арга зүй боловсруулах;
- Судалгааны асуулга, нөхөх зааврыг боловсруулах;

- ЭМЯ-ны Анагаах ухааны ёс зүйн хороо, ҮСХ-ны Арга зүйн байнгын, Даргын зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, зөвшөөрөл авах;
- Таниулсан зөвшөөрлийн хуудас, эцэг, эх, асран хамгаалагчид, сургуулийн удирдлагад илгээх албан захидлын эхийг бэлтгэх;
- БШУЯ-ны дэмжлэгтэйгээр таниулсан зөвшөөрөл болон судалгааны мэдээллийн хуудсыг эцэг, эх, асран хамгаалагчдад хүргэх;
- Судалгааны мэдээллийг оруулах, шалгах, засварлах, үр дүнгийн хүснэгт гаргах программын даалгаврыг бэлтгэх;
- Судалгааны мэдээлэл цуглуулах ярилцлага авагч, багийн ахлагч нарт зориулсан сургалт зохион байгуулах;

II. Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:

- Судалгааны мэдээллийг нийслэл, орон нутагт цуглуулах;

III. Мэдээлэл боловсруулалт, тайлан бичих ажлын хүрээнд:

- Цуглуулсан мэдээллийг шалган, засварлаж, кодлох;
- Судалгааны мэдээллийг программд оруулах;
- Үр дүнгийн хүснэгтийг боловсруулах;

IV. Үр дүнг тархаах, хэвлэн нийтлэх ажлын хүрээнд:

- Нэгдсэн тайланг бичиж, тархаах;
- Анхдагч мэдээллийн нууцлалыг хангах;
- Судалгааны бүхий л үе шатны ажилбарыг архивлах

зэрэг ажлуудыг тус тус зохион байгуулж хэрэгжүүлэв.

Судалгааны хөтөлбөрийг ажлын хэсэгт танилцуулан, санал зөвлөмжийг тусган боловсруулсан бөгөөд тухайн асуудлаар дагнан судалдаг мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран ажилласан.

### *1.8. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт*

Судалгааны мэдээлэл цуглуулалт эхлэхээс өмнө багийн ахлагч, мэдээлэл цуглуулагч, мэдээлэл шивэгч нарт батлагдсан асуулга, хөтөлбөр, зааврын дагуу сургалт зохион байгуулж, заавар, зөвлөгөө өгч, тусгайлсан гарын авлагаар хангасан. Сургалтын дараа оролцогчдыг тодорхой байршилд туршилт хийлгэж, гарч буй алдаа, тодорхой бус асуудалд газар дээр нь зөвлөгөө өгч, зохих хэмжээний дадал эзэмшүүлсний дараа мэдээлэл цуглуулах байршлуудад хуваарилсан.

Мэдээлэл цуглуулах үед багуудын үйл ажиллагааг шалгахаар хяналт, мониторинг хийх, зөвлөн туслах ажлыг судалгааны ажлын хэсгийн төлөөлөл хариуцан зохион байгуулсан. Судалгааны мэдээллийн шивэлтийг CS-Pro, үр дүнг боловсруулж, шинжилгээ хийхэд SPSS программ хангамжийг ашигласан.

### 1.9. Нууцлал болон ёс зүйн асуудал

Тус судалгааг гүйцэтгэхэд дараах ёс зүйн зарчмуудыг баримтлан ажилласан.

#### Судалгаанд оролцох зөвшөөрөл

Насанд хүрээгүй хүүхдээс судалгааны мэдээлэл цуглуулахдаа эцэг, эх, асран хамгаалагчаас судалгаанд оролцуулах зөвшөөрөл авсны үндсэнд дээр судалгаанд хамруулах зарчимтай. Энэ зарчмын дагуу судалгаанд оролцохоор сонгогдсон сурагчдын эцэг, эх, асран хамгаалагчдад урьдчилан мэдээлэл хүргүүлж, таниулсан зөвшөөрлийн хуудсыг илгээж, гарын үсэг авсан. Мөн судалгаанд оролцогч хүүхэд тус бүрд судалгааны агуулга бүхий дэлгэрэнгүй мэдээллийг өгч, тайлбарласны дараа судалгаанд хамруулсан (Хавсралт 1).

#### Мэдээллийн нууцлал

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үе шат бүрд Статистикийн тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудыг тус тус баримтлан, энэ талаар оролцогчдод мэдээлэл цуглуулалтаас өмнө бичгээр урьдчилан мэдэгдсэн төдийгүй ангид судалгааг удирдсан болон багш нараас бүлгийн ярилцлага авсан багийн гишүүд аман танилцуулга хэлбэрээр давхар хүргэсэн.

# 2. ЭСЭН МЭНД АМЬДРАХ ЭРХ

## Эсэн мэнд амьдрах эрхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтууд

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхэд чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах, насандаа тохирсон шим тэжээлтэй хоол хүнс хэрэглэх, ундны цэвэр усаар хангагдах, амь нас эрүүл мэндэд аюул учруулахгүй орчинд амьдрах эрхүүд ордог. Эсэн мэнд амьдрах эрхийг Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Амьд явах эрх” гэж, Хүүхдийн эрхийн конвенцын 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхэд амьд явах жам ёсны эрхтэй” хэмээн тус тус тодорхойлсон.

Суралцагч хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангахын тулд сургууль дотуур байрандаа эрүүл мэндийн үйлчилгээ авах, нас биеийн хөгжлийн шаардлагад нийцсэн шим тэжээлтэй хоол хүнс хэрэглэх, цэвэр ус уух, аливаа осол, гэнэтийн аюул, орчны эрсдэлээс хамгаалагдахад чиглэсэн тодорхой заалтууд Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудад тусгагдсан байдаг. Тухайлбал, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлд ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд  суралцагчдыг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих; эрүүл мэндийг дэмжсэн, шим тэжээллэг, амин дэмээр баялаг хоол, хүнсний үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах үүргийг сургуулийн захиралд харьцуулсан бол мөн хуулийн 38 дугаар зүйлд нутгийн өөрөө удирдах болон  захиргааны байгууллага нь шаардлагатай хүүхдэд аюулгүй тээвэр, дотуур байраар үйлчлэх, сургууль, дотуур байрын барилга байгууламж түүний засвар үйлчилгээг хариуцаж сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулах нөхцөлийг хангах , дотуур байранд амьдарч байгаа суралцагчийн эрүүл мэнд болон хоол хүнсний аюулгүй байдлыг хангах үүргийг хүлээхээр хуульчлагдаад байна.

Суралцагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хэрхэн хангахыг дараах стандартуудад  нарийвчлан тусгасан байдаг. Үүнд:Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 6782:2019;

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага. MNS 6781:2019;
- “Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6799:2019;
- Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал: MNS 6948:2021 зэрэг багтана.

Эдгээр стандартад тусгасан зарим шалгуур үзүүлэлтийг тус судалгаанд ашиглав. Ингэхдээ суралцагчдын сурах хөгжих, эсэн мэнд амьдрахад тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгосон. Үүнд, сургууль, дотуур байрны орчны аюулгүй байдал, цэвэр усны хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж зэрэг багтсан.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3.1.4-т заасан “сургуулийн орчин гэдгийг сургуулийн барилга байгууламж, эдэлбэр газраас хааш хаашаа 150 метр газар” гэж тогтоосныг үндэслэн энэ орон зайд суралцагчдын аюулгүй байдлыг хэрхэн хангаж буйг ажиглалтын аргаар судлав. Мөн суралцагчдын сургуульд ирж очих замын аюулгүй байдалд тулгарч буй эрсдэлийг тодорхойлуулахыг зорьсон нь эсэн мэнд амьдрах эрхээ эдлэхэд онцгой чухал үзүүлэлт болохыг дэлхийн хэмжээнд анхаарч буйтай уялдуулсан[11] болно.

Сургуулийн барилга байгууламжийг хүн амын тоонд нийцүүлсэн байдлаар суурьшлын бүсүүдэд байгуулж сургадаг арга нь дэлхийн олон оронд суралцагчдыг сургуульдаа аюулгүй зорчихыг дэмждэг нийтлэг арга юм. Хүн ам нь тархан суудаг Монгол Улсын хувьд засаг захиргааны анхан шатны нэгж болох сумын төв болон томоохон суурин газар бүрд сургууль байгуулсан байдаг. Малчдын хүүхдийн хувьд баг, сумын төвд байгуулсан сургуулийн дэргэдэх дотуур байранд хичээлийн жилийн турш амьдрах боломжоор хангагддаг. 2022-2023 оны хичээлийн жилд Монгол Улсын хэмжээнд нийт 548 дотуур байранд 35,077 хүүхэд амьдарч байсан. Үүнээс нийслэлд 20 (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулиудын дотуур байр багтсан), аймгийн төвд 50, сумдад 418, багуудад 60 дотуур байр үйл ажиллагаа явуулж байв.[12]

Суурин газруудад нийтийн тээврийн болон хувийн унаа, таксигаар зорчих нь элбэг. Мөн сургууль нь ойрхон, эсвэл нийтийн тээврийн маршрутгүй, гэр бүл нь хувийн унаагүй зэрэг шалтгаанаар сургуульдаа алхаж очдог хүүхдүүд бий. Хүүхдүүдийн замд харанхуй гудамж, золбин ноход, архины хамааралтай хүмүүс цуглардаг газар гэх мэт эрсдэлтэй таардаг талаар 2023 оны 8 дугаар сард болсон Хүүхдийн оролцооны үндэсний чуулганы төлөөлөгч хүүхдүүд мэдээлжээ.[13]

Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. MNS 6948:2021 стандартад сургууль бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх, гамшгийн үед боловсролын үйлчилгээг тасралтгүй явуулах, гамшиг тохиолдсон үед сургуулийн барилга байгууламжаас эсэн мэнд гарах дадлага сургууль хийх талаар тусгасан бөгөөд Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага. MNS 6781:2019 зэрэг баримт бичигт гамшгийн үед ашиглах орц гарцын

11 Trude Nilsen, Ronny Scherer. (2019) Closing the gaps? Differential effectiveness and accountability as a road to school improvement. School effectiveness and school improvement. An international Journal of Research, Policy and Practice. Volume 30. https://www.tandfonline.com/doi/full/10.1080/09243453.2019.1623450 Retrieved: October 20. 2023

12 Засгийн газрын хэрэг эрхлэх газар. 2023. Сурч боловсрох эрх: дотуур байр үндэсний II зөвлөгөөн"-ий тайлан

13 Хүүхдийн оролцооны үндэсний чуулган.20236 https://news.mn/r/2668522/

тэмдэглэгээтэй байх, бүх хүүхэд сургуулийнхаа гадаа цугларах зай талбайтай байх зэрэг шаардлагууд багтсан нь суралцагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хангахад чиглэжээ.

Өсвөр насныхны эсэн мэнд амьдрах эрхийн хэрэгжилтийн талаар тодруулахын тулд хэрэгжиж буй стандартуудын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан хүүхдээс асуулгын аргаар, багш нараас зорилтот бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулснаас гадна судлаачид тусгайлан бэлтгэсэн ажиглалтын хуудсыг ашиглан үнэлгээ хийсэн. Цугларсан мэдээлэлд тулгуурлан судалгааны үр дүнг дараах хүрээгээр гаргав. Үүнд:

1. Сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий үнэлгээ,
2. Сургуулийн гадаад орчны үнэлгээ,
3. Сургууль руу ирж, очих замын аюулгүй байдал,
4. Сургуулийн дотоод орчны үнэлгээ,Дотуур байрны аюулгүй байдал,Жендэр ба аюулгүй байдал,
5. Гамшгийн бэлэн байдал.

## *2.1. Сургуулийн орчны аюулгүй байдлын ерөнхий үнэлгээ*

Олон улсын хэмжээнд сургуулийн орчныг судлахдаа хүүхэд боловсрол эзэмших явцад буй бүхий л барилга байгууламж, ирж очих зам, тээврийн хэрэгсэл, спорт, урлаг, чөлөөт цагийн танхим, талбай, туршилт шинжилгээ, хээрийн аяллын бааз зэрэг өргөн хүрээний ойлголтыг агуулдаг. Тус судалгаанд **"сургуулийн орчин"**-г хичээлийн байр, спорт, урлагийн танхим, цайны газар, угаалгын өрөө, дотуур байр, сургуулийн гадна талбай, ирэх очих зам зэргээр хязгаарлав. Хүүхдүүдийн 72.8 хувь нь өнгөрсөн жилийн хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдаагүй гэж хариулсан бөгөөд үлдсэн 27.2 хувьд нь сургуулийн аль хэсэгт алдагдсаныг харъя (Зураг 2.1).

*Зураг 2.1. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, байршлаар*




Тухайлбал, аюулгүй байдал алдагдсан сурагчдын 29.5 хувь нь анги буюу хичээлийн танхимд аюулгүй байдал нь алдагдсан гэжээ. Тус үзүүлэлтийн

хувь хүүхдийн нас багасах тусам өндөрсөх хандлагатай байгаа нь 17 настай хүүхдүүдийн 28.7 хувь, 14 насныхны 39.0 хувь байгаагаас харагдаж байна.

*Хүснэгт 2.1. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар, 2023 он*

| Үзүүлэлт | 13 нас | 14 нас | 15 нас | 16 нас | 17 нас |
|---|---|---|---|---|---|
| Нийт (хувиар) | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Сургуулийн коридор | 16.5 | 24.7 | 21.1 | 24.5 | 35.2 |
| Ангид буюу хичээлийн танхим | 0.0 | 39.0 | 36.4 | 30.3 | 28.7 |
| Дотуур байр | 0.0 | 3.6 | 3.0 | 2.1 | 5.2 |
| Ариун цэврийн өрөө, жорлон | 0.0 | 3.4 | 16.8 | 12.4 | 9.7 |
| Цайны газар | 0.0 | 1.6 | 3.1 | 1.5 | 4.9 |
| Биеийн тамирын заал, урлагийн заал зэрэг олон хүүхэд цуглардаг газар | 0.0 | 12.8 | 11.2 | 19.6 | 10.4 |
| Бусад | 83.5 | 14.9 | 8.4 | 9.4 | 5.8 |

Биеийн тамирын заал гэх мэт олон хүүхэд зэрэг цуглардаг газар 16 настай хүүхдийн 19.6 хувь нь аюулгүй байдал алдагдсан гэсэн нь энэ үзүүлэлтийн хувьд хамгийн өндөр үзүүлэлттэй насны бүлэг болжээ. Эдгээр газарт аюулгүй байдал нь алдагдсан хүүхдүүд хотын сургуульд 2.5 хувиар илүү байгаагаас үзэхэд олон хүүхэд суралцдаг, ачаалал ихтэй сургуулиудад эдгээр танхимуудыг нэг дор олон анги, бүлгүүд зэрэг ашиглаж буйтай холбон тайлбарлаж болох юм. Ялангуяа, биеийн тамирын хичээлийг нэг зааланд хоёр ба түүнээс дээш анги, ижил бус насны хүүхдүүд хамт ороход хүүхдүүдэд тав тух алдагдаж байгаа зарим жишээ ажиглагдав.

Байршлын хувьд хотын сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдах нь хөдөөгийн сургуулийнхаас 4.2 хувиар их байв.

*Зураг 2.2. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан газар, байршлаар*




## 2.2. Сургуулийн гадаад орчны үнэлгээ

“Сургууль нь зөвхөн хичээл сургалтын барилга байгууламж бус түүнийг тойрсон ногоон байгууламж, тоглоомын болон спортын талбай, хашаа, сургуулийн эзэмшил газар болон эргэн тойрон 150 метрт байгаа зай талбайнаас бүрдэнэ” гэх MNS 6782:2019 стандартад заасан шаардлагыг тус судалгааны шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

Ажиглалт судалгааны үр дүнгээс харахад сургуулиудын эргэн тойронд (150 м хүртэлх газар) хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулж болзошгүй нөхцөл байна. Сургуулийн эргэн тойрны 150 м хүртэлх газарт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийг дүгнэхэд 60-аас доош хувьтай нь нийт сургуулиудын 17.6 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлтийг хот, хөдөөгийн сургуулиар нь тодруулбал хөдөөгийн сургуулийн хэрэгжилт хотынхоос 2 дахин муу буюу 21.9 хувь нь хангалтгүй байна (Хүснэгт 2.2).

*Хүснэгт 2.2. Сургуулийн эргэн тойрны 150 м хүртэлх газарт хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 51.0 | 31.4 | 17.6 | 100.0 |
| Хот | 57.9 | 31.6 | 10.5 | 100.0 |
| Хөдөө | 46.9 | 31.3 | 21.9 | 100.0 |

Хүснэгтээс харахад сургууль орчмын хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилт хангалттай буюу 80-100 хоорондох онооны түвшний үнэлгээнд нийт сургуулийн 51.0 хувь нь хүрсэн байв. Хөдөөгийн хувьд ЕБС-ийн эргэн тойронд буй хуучин барилгууд хэсэгчлэн эвдэрч, нурсан, шугам

хоолойн засварын улмаас онгорхой нүх үлдээсэн зэрэг байдал хүүхдүүд гэмтэж бэртэх, осолд өртөж болзошгүй нөхцөл үүсгэж байна. Харин хотын сургуулиудын хувьд автозамын хөдөлгөөний эрсдэл нь илүү байгаа нь ажиглалтын явцад илэрсэн.Сургуулийн орчимд ногоон байгууламжтай байх нь сурагчдын сурлагын амжилт болон сэтгэцийн эрүүл мэндэд эерэг нөлөөтэй олон улсын судлаачид[14] тогтоосон байдаг.  Монгол Улсын хувьд сургуулийн орчны аюулгүй байдлын стандартад сургуулийн "эзэмшил газрын 25-аас доошгүй хувь нь ногоон байгууламж байна" хэмээн заасан. Үүний хэрэгжилтийг дараах хүснэгтээс харна уу.

*Хүснэгт 2.3. Сургуулийн гадаа талбайн 25 хүртэлх хувьд ногоон байгууламжтай эсэх, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 52.9 | 37.3 | 9.8 | 100.0 |
| Хот | 57.9 | 26.3 | 15.8 | 100.0 |
| Хөдөө | 50.0 | 43.8 | 6.3 | 100.0 |

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 52.9 хувь нь стандартад нийцсэн ногоон байгууламжтай, харин 37.3 хувь нь цөөн мод, бага хэмжээний зүлгээр хязгаарлагдсан байна. Хотын сургуулиудын хувьд "хангалтгүй" гэсэн үзүүлэлт хөдөөгийнхөөс 10 орчим хувиар илүү байгаа нь ногоон байгууламж бий болох зай талбайн хомсдолтой холбоотой байж болох юм.

Сургуулийн эзэмшил газрын бүрэн хашаалагдсан байдал нь хүүхдийг автомашины осол, ойр орчим яваа бусад хүмүүсийн халдлага, орчны сөрөг нөлөөнөөс хамгаалах, тэдэнд хараа хяналт тавихад чухал ач холбогдолтой.

*Хүснэгт 2.4. Сургуулийн эзэмшил газар хашаалагдсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 90.2 | 3.9 | 5.9 | 100.0 |
| Хот | 100.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 84.4 | 6.3 | 9.4 | 100.0 |

Сургуулиудын эзэмшил газрын хашаалагдсан байдлыг харьцуулахад 90.2 хувь нь бүрэн, 3.9 хувь нь дунд зэрэг, харин 5.9 хувь нь хангалтгүй байв. Харин хотын сургуулиудын эзэмшлийн газар бүрэн хашаалагдсан байв.Хөдөөгийн сургуулиудын 76.9 хувь, нийт сургуулиудын 78.9 хувьд нь гадаа тоглоомын болон биеийн тамирын талбайд осол гэмтлээс сэргийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй байна.

Сургуулийн гадаад орчин гэрэлтүүлгийн хүртээмжийг ач холбогдлынх нь хувьд чухалчилж мөн үнэлсэн.

14 Raquel. B etc (2023) School Greenness and Student-level Academic Performance: Evidence from the Global South. Journal Advanced Earth and Space Sciences. Https://agupubs.onlinelibrary.wiley.com/doi/10.1029/2023gh000830

*Хүснэгт 2.5. Сургуулийн гадаад орчны гэрэлтүүлгийн хүртээмж, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 62.7 | 25.5 | 11.8 | 100.0 |
| Хот | 63.2 | 21.1 | 15.8 | 100.0 |
| Хөдөө | 62.5 | 28.1 | 9.4 | 100.0 |

Хотын сургуулийн 15.8 хувь, хөдөөгийн сургуулийн 9.4 хувьд гэрэлтүүлэг хангалтгүй байна.

## 2.3. Сургуульд хүрэх замын аюулгүй байдал

Сургуульд хүрэх замын аюулгүй байдлыг хангаж, таатай нөхцөл бүрдүүлэх нь хүүхдийн боловсрол эзэмшихэд чухал ач холбогдолтой. Энэ хүрээнд сургууль орчмын авто замын аюулгүй байдлыг хангах, хурд сааруулагч суурилуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах шаардлагыг сургуулийн аюулгүй байдлын стандартад тусгасан байдаг.

Сургууль руу ирж, очих замын аюулгүй байдлын талаар хүүхдүүдээс асууж тодруулав.

*Зураг 2.3. Сүүлийн 1 сарын хугацаанд сургуульд ирж, очсон байдал, байршлаар*




Хотын хүүхдүүдийн 38.8 хувь нь ямар нэг тээврийн хэрэгслээр зорчдог байна. Эдгээрт 18.4 хувь нь нийтийн тээврийн, 11.3 хувь нь хувийн унаа, 4.6 хувь нь таксигаар, 4.5 хувь нь сургуулийн автобусаар тус тус зорчиж байна. Хөдөөгийн сурагчдын 90.0 хувь, хотын сурагчдын 57.9 хувь нь сургуульдаа явганаар ирж очиж байна.

Хүүхдүүдээс амьдарч буй газар, сургууль хооронд зорчиход тулгарч буй бэрхшээлийн талаар асуухад дараах дүр зураг харагдаж байна.

*Зураг 2.4. Сургууль хүрэх замд буй бэрхшээлүүд, байршлаар*




Хотын хүүхдүүдийн саад бэрхшээлтэй тулгарах байдал хөдөөгийн хүүхдүүдээс 10.5 хувиар илүү байна. Бэрхшээлийн төрлөөр харьцуулбал, автозамын түгжрэл (12.3 хувь), нохойноос айх айдас (9.4 хувь), гэрэлтүүлэг муу байдал (9.1 хувь), шороон замын хальтаргаатай байдал (8.0 хувь) зэрэг байв.

*Хүснэгт 2.6. Сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга бүхий самбар байршуулсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 15.7 | 54.9 | 29.4 | 100.0 |
| Хот | 10.5 | 73.7 | 15.8 | 100.0 |
| Хөдөө | 18.8 | 43.8 | 37.5 | 100.0 |

Сургуулийн орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гарц, тэмдэг тэмдэглэгээ, анхааруулга бүхий самбар зэрэг урьдчилан сэргийлэх хэрэгслийн хүртээмжийн хувьд 84.3 хувь нь хангалтгүй байгаа нь ажиглалтаар илэрчээ. Энэ байдлыг нөхөж суралцагчдын сургууль орчимдоо аюулгүй зорчиход эцэг, эх, асран хамгаалагчдын сургуулийн захиргаатай хамтран хэрэгжүүлдэг School Police хөтөлбөр чухал үүрэгтэй байгааг Тээврийн цагдаагийн газраас мэдээлжээ.[15]

Сургууль хүрэх замын аюулгүй байдлын талаар чанарын судалгаанд хамрагдсан багш нарын өгсөн ярилцлагаас сийрүүлье.

15 https://www.mnb.mn/i/104626

*Хотын сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Гэр хорооллын гудамж гэрэлгүй харанхуй, гэрэлтүүлэг байхгүй, траншейны нүх олон, хүүхэд унасан тохиолдол гарч байсан. Эзэнгүй хаягдсан барилга, байгууламж ихтэй, золбин нохой дайрдаг."*

## 2.4. Сургуулийн дотоод орчин

Сургуулийн дотоод орчны үнэлгээнд эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх, хоол хүнсний аюулгүй байдал, цэвэр усны хангамж зэргийг багтаан судлав. Мөн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг жендэрийн асуудалтай холбон дүгнэсэн.

### Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх

Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд бүгд эмчтэй байсан бөгөөд тэдний ажил үүрэгт эрүүл ахуй, халдвар, хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд дотоод хяналтыг тогтмол хийх үйл ажиллагаа багтсан байна (Хүснэгт 2.7).

*Хүснэгт 2.7. Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн талаар хэрэгжүүлэх дотоод хяналтын байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 66.7 | 25.5 | 7.8 | 100.0 |
| Хот | 68.4 | 31.6 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 65.6 | 21.9 | 12.5 | 100.0 |

Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн байдалд тавьж буй дотоод хяналтын хувьд 66.7 хувь нь хангалттай, 33.3 хувь нь хангалтгүй байв. Энэ үнэлгээнд сургуулийн, цайны газар, бие засах газрын ариун цэврийн байдал, халдвар хамгааллын шаардлага зэргийг шалгуур үзүүлэлт болгов.

### Хоол хүнсний аюулгүй байдал

*Хүснэгт 2.8. Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 66.7 | 29.4 | 3.9 | 100.0 |
| Хот | 68.4 | 26.3 | 5.3 | 100.0 |
| Хөдөө | 65.6 | 31.3 | 3.1 | 100.0 |

Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын системийн талаар тодруулахад 66.7 хувь нь хангалттай, харин 3.9 хувь нь хангалтгүй байна. Үнэлгээнд сургуулийн цайны газарт борлуулж байгаа бүтээгдэхүүн болон тэдгээрийн хадгалалтын хугацааны мэдлэгийг суурь болгож тодорхойлсон.

### Ундны цэвэр усаар хангагдах эрх

Тус үнэлгээнд сургууль, дотуур байрны давхар бүрд цэвэр усны хүртээмжтэй байхаар тусгасан MNS 6782:2019 стандартын шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үнэлгээнд хамрагдсан нийт сургуулийн 66.7 хувь нь стандартыг хангалттай, 13.7 хувь нь дунд зэрэг, 19.6 хувь нь хангалтгүй хэрэгжүүлж байв. Хөдөөгийн дөрвөн сургууль тутмын нэг нь ус цэвэршүүлэх төхөөрөмж тавих усны эх үүсвэр байхгүй, зөөврийн цэвэршүүлсэн усыг тогтмол авч хэрэглэх төсөв зардлын хүрэлцээгүй байдал зэргээс шалтгаалсан цэвэр усны хүртээмжийн асуудалтай байна.

*Хүснэгт 2.9. Ус цэвэршүүлэгч байршуулсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 66.7 | 13.7 | 19.6 | 100.0 |
| Хот | 78.9 | 10.5 | 10.5 | 100.0 |
| Хөдөө | 59.4 | 15.6 | 25.0 | 100.0 |

## *2.5. Жендэр ба аюулгүй байдал*

Эрэгтэй сурагчдын хувьд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдах нь эмэгтэй сурагчдаас 6.4 хувиар илүү байна.

*Зураг 2.5. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийн орчинд аюулгүй байдал алдагдсан эсэх, хүйсээр*



Зураг 2.5-аас харахад эрэгтэй сурагчдын хувьд ариун цэврийн өрөө буюу бие засах газар орчимд эмэгтэй сурагчдаас 12.7 хувиар илүү хэмжээнд аюулгүй байдал нь алдагдсан гэжээ.

Эдгээр дүнд биеийн тамирын зааланд эрэгтэй, эмэгтэй хүүхдийн хувцас солих орчныг тусгаарлах байдал хангалтгүй байгаа нь нөлөөлж болох талтай. Ажиглалтын үр дүнгээр нийт сургуулийн бараг тал хувьд нь эмэгтэй, эрэгтэй сурагчдад тусгайлан зориулсан хувцас солих орчин бүрдээгүй нь харагдсан.

*Хүснэгт 2.10. Биеийн тамирын зааланд эмэгтэй, эрэгтэй хүүхдийн хувцас солих орчныг тусгаарласан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 41.2 | 11.8 | 47.1 | 100.0 |
| Хот | 52.6 | 10.5 | 36.8 | 100.0 |
| Хөдөө | 34.4 | 12.5 | 53.1 | 100.0 |

Сургууль дахь эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөний халуун усны хангамжийн талаар тодруулахад 45.1 хувь нь хангалттай, 7.8 хувь нь дунд зэрэг, 47.1 хувь нь хангалтгүй байна. Хөдөөгийн сургуулиудын 69.2 хувьд эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөнд халуун ус тогтмол бус байдаг байна (Хүснэгт 2.11).

*Хүснэгт 2.11. Эмэгтэй сурагчдын ариун цэврийн өрөөний халуун усны хангамж, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 45.1 | 7.8 | 47.1 | 100.0 |
| Хот | 63.2 | 15.8 | 21.1 | 100.0 |
| Хөдөө | 34.4 | 3.1 | 62.5 | 100.0 |

Эмэгтэй сурагчдын ариун цэврийн өрөөнд халуун ус хангалтгүй байгаагийн шалтгаан төвийн шугамд холбогдоогүй, нүхэн жорлон ашигладагт байна.

Сургуульд ирж, очих замд хөвүүдийн 59.5 хувь нь ямар ч саад бэрхшээл тулгараагүй гэсэн бол эмэгтэй сурагчдын 64.0 хувьд нь ямар нэгэн бэрхшээл саад тулгарчээ (Зураг 2.6). Эмэгтэй сурагчдын хувьд гэрлэн дохионы ажиллагаагүй байдал, халтиргаатай зам, гэрэлтүүлэггүй гудамж, автозамын түгжрэл, зэргийг саад бэрхшээл гэж үзэх нь хөвүүдээс илүү байна. Харин архи уудаг хүмүүс цуглардаг газар, нохой, автомашины хөдөлгөөнөөс эмээх нь хүйсийн ялгаа багатай байна.

*Зураг 2.6. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуульдаа ирж очих замд ямар нэг саад бэрхшээл учирсан эсэх, хүйсээр*




## 2.6. Гамшгийн бэлэн байдал

Гамшиг, онцгой байдлын давтамж нэмэгдэж байгаа өнөө цаг үед олон хүүхдийг нэг дээвэр дор цуглуулж, хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийн орчны хувьд гамшгийн бэлэн байдал нэн чухал юм. Судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын 80.4 хувь нь гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй байна (Хүснэгт 2.12). Гэвч сургуулийн төлөвлөлт, барилгын зураг, ойр орчмын барилга байгууламжийн хоорондын зай хэмжээ нь гамшгийн бэлэн байдлын шаардлагад нийцэхгүй байгаа нь ажиглалтын судалгаагаар гарсан юм.

*Хүснэгт 2.12. Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөтэй эсэх, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 80.4 | 9.8 | 9.8 | 100.0 |
| Хот | 78.9 | 15.8 | 5.3 | 100.0 |
| Хөдөө | 81.3 | 6.3 | 12.5 | 100.0 |

Олон хүн нэг дор цуглардаг газруудад тавигддаг шаардлагуудын нэг нь гамшгийн үед яаралтай, аюулгүй гарах гарц, хаалга, тэмдэглэгээний

хүртээмжтэй байдал юм. Сургууль доторх урлаг, соёлын танхимд хоёроос доошгүй гарц, тухай бүр дээр тэмдэглэгээ байрлуулсан эсэх талаар тодруулахад, сургуулиудын 31.4 хувьд хангалттай байв.

*Хүснэгт 2.13. Урлаг, соёлын танхимын гарц, тэмдэглэгээ байрлуулсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 31.4 | 25.5 | 43.1 | 100.0 |
| Хот | 42.1 | 36.8 | 21.1 | 100.0 |
| Хөдөө | 25.0 | 18.8 | 56.3 | 100.0 |

Хөдөөгийн зарим сургуулиуд нь урлагийн танхимгүй байх бөгөөд хичээлийн танхим эсхүл сумын соёлын төвд аливаа арга хэмжээг зохион байгуулдаг байна. Энэ нь  гамшиг болсон үед хүүхдүүдийг хэрхэн гаргах тэмдэг тэмдэглэгээ байршуулах боломжгүй шалтгаан болж байна. Харин төв суурин газарт байгаа, хуучны барилгатай сургуулиудад аваарын хаалга, нэмэлт орц, гарцгүй байв (Хүснэгт 2.14).

*Хүснэгт 2.14. Гамшгийн үед авах арга хэмжээг дүрсэлсэн тэмдэг тэмдэглэгээний байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 49.0 | 25.5 | 25.5 | 100.0 |
| Хот | 57.9 | 36.8 | 5.3 | 100.0 |
| Хөдөө | 43.8 | 18.8 | 37.5 | 100.0 |

Гамшиг, осол, аваарын үед сургуулиас хэрхэн гарахыг харуулсан тэмдэг, тэмдэглэгээ байгаа эсэхэд сургуулиудын 49.0 хувьд хангалттай байна. Хангалтгүй үнэлгээтэй сургуулиудын хувьд гамшгийн үеийн төлөвлөгөөндөө схем зураггүй байгаа нь нөлөөлжээ.

*Хүснэгт 2.15. Сургуулийн гадна талбайн хүртээмжтэй байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 80.4 | 13.7 | 5.9 | 100.0 |
| Хот | 73.7 | 26.3 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 84.4 | 6.3 | 9.4 | 100.0 |

Сургуулийн гадаа талбайн хэмжээ нь гамшиг болсон үед бүх хүүхэд нь сургуулийн барилга дотроос гарч гадаа талбайдаа цугларах боломжтой байх ёстой гэж олон улсын Хүмүүнлэгийн үеийн хүүхэд хамгааллын стандарт болон Монгол Улсын Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал MNS 6948:2021 стандартад орсон. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 80.4 хувь нь сургуулийн гадна талбайд сургуулийн бүх хүүхэд, багш нар цугларах боломжтой байсан бол 13.7 хувь нь хэсэгчилсэн буюу дунд зэрэг, үлдсэн 5.9 хувь нь огт цугларах боломжгүй байна.

## *2.7 Дотуур байрны орчны аюулгүй байдлын үнэлгээ*

2021-2022 онд Монгол Улсын хэмжээнд нийт 548 дотуур байранд 34,546[16] хүүхэд амьдарч байжээ. Судалгаанд хамрагдсан сургуулиудын 54.9 хувь нь дотуур байртай, 45.1 хувь нь дотуур байргүй байлаа (Хүснэгт 2.16).

*Хүснэгт 2.16. Дотуур байртай эсэх, байршлаар*

| | Тийм | Үгүй | Нийт |
|---|---|---|---|
| БҮГД | 54.9 | 45.1 | 100.0 |
| Хот | 10.5 | 89.5 | 100.0 |
| Хөдөө | 81.3 | 18.8 | 100.0 |

Судалгааны хүрээнд дотуур байрны нөхцөл байдлыг MNS 6781:2019 стандартын зарим шалгуур үзүүлэлтийн дагуу ажиглалт болон багш нарын төлөөллөөс бүлгийн ярилцлагаар тус тус тодруулав.Нийт судалгаанд оролцсон сургуулиудын 71.4 хувьд нь дотуур байрны эзэмшил газар бүрэн хашаалагдсан байв.

*Хүснэгт 2.17. Дотуур байрны эзэмшил газрын хашаалагдсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 71.4 | 21.4 | 7.1 | 100.0 |
| Хот | 100.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 69.2 | 23.1 | 7.7 | 100.0 |

Судалгаанд хамрагдсан дотуур байруудын 75.0 хувь нь автомашины зогсоолгүй, 25.0 хувь нь автомашины зогсоолтой ч сургуулийн багш, ажилчдын унаанаас бусад машин оруулдаггүй гэсэн хариулт өгчээ.

*Хүснэгт 2.18. Дотуур байрны эзэмшил газрын автомашины зогсоол байгуулаагүйд анхаарсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 75.0 | 21.4 | 3.6 | 100.0 |
| Хот | 100.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 73.1 | 23.1 | 3.8 | 100.0 |

Судалгаанд хамрагдсан сургуулиудын дотуур байрны 50.0 хувь нь давхар бүрд ус цэвэршүүлэгч болон хүүхэд амрах булантай байна. Үлдсэн хувьд эдгээр зүйлс хүрэлцээгүй байгаад төсөв мөнгөний хүрэлцээгүй байдлаас шалтгаалж байна гэж хариулсан.

16 Сурч боловсрох эрх: Дотуур байр үндэсний II зөвлөгөөн. БШУЯ. 2023 он

*Хүснэгт 2.19. Давхар бүрд хүүхэд амрах булан байгуулсан байдал, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 50.0 | 28.6 | 21.4 | 100.0 |
| Хот | 100.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 46.2 | 30.8 | 23.1 | 100.0 |

Судалгаанд хамрагдсан хотын сургуулиудад ариун цэврийн байгууламж нь дотроо учраас ариун цэврийн байгууламжид хүрэх зам 100 хувь аюулгүй гэж дүгнэгдсэн бол хөдөөгийн сургуулийн дотуур байрны 46.2 хувь нь аюулгүй гэж дүгнэгдсэн.

*Зураг 2.7. Ариун цэврийн байгууламж хүрэх замын аюулгүй байдал, байршлаар*




Дотуур байрны багш нарын зүгээс ариун цэврийн байгууламж хүрэх замыг сайжруулах, шинэчлэх хүсэлт гаргадаг ч төсөв, санхүүгийн шалтгаанаас хойшлогддог гэж тайлбарласан.

ХЭК-ийн 8.2 зүйлд “Хүүхэд гэр бүлийнхэнтэйгээ хамт байх боломжийг засгийн газар хханган ажиллах ёстой” хэмээн заасан байдаг.

*Хүснэгт 2.20. Эцэг, эх хүүхэдтэйгээ чөлөөтэй уулзах боломжийг хангасан уулзалтын өрөөтэй эсэх, хувиар, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 46.4 | 28.6 | 25.0 | 100.0 |
| Хот | 50.0 | 50.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 46.2 | 26.9 | 26.9 | 100.0 |

Судалгаанд хамрагдсан нийт дотуур байрны 46.4 хувь нь уулзалтын өрөөтэй байна (Хүснэгт 2.21). Үлдсэн 53.6 хувьд нь тусгайлан өрөө гаргах зай талбайн боломжгүй учраас жижүүрийн өрөөг уулзалтад ашигладаг.

Ихэнх дотуур байранд өрөөнүүдийг хүйсийн хувьд давхраар нь эсхүл хэсгээр нь шийдсэн байна. Гэхдээ хөдөөгийн сургуулийн 7.1 хувь нь хангалтгүй үзүүлэлттэй байгаа нь нэг гэр бүлийн хүүхдүүдийг хүйс харгалзахгүй хамтад нь байрлуулсантай холбоотой.

*Хүснэгт 2.21. Сургуулийн дотуур байрны өрөөнүүд хүйсийн хувьд тусдаа байдаг эсэх, байршлаар*

| | Хангалттай 80-100 | Дунд зэрэг | Хангалтгүй 60-аас доош | Нийт |
|---|---|---|---|---|
| БҮГД | 82.1 | 10.7 | 7.1 | 100.0 |
| Хот | 100.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Хөдөө | 80.8 | 11.5 | 7.7 | 100.0 |

Дотуур байранд гадны хүн нэвтрэхэд баримтлах дэгийг дотоод журамдаа тусгасан ч, энэ талаарх эцэг, эхийн мэдлэгийн дутмаг байдал, ээлжийн жижүүрүүд олон солигддогийн улмаас зарим дотуур байранд гадны хүн чөлөөтэй нэвтрэн хүүхдэд хор хохирол учруулахуйц нөхцөл үүсгэж болзошгүй талаар бүлгийн ярилцлагын үеэр жишээ татагдаж байсан.

## ДҮГНЭЛТ

Боловсролын орчинд сурагчдын эсэн мэнд амьдрах эрхийг хангахад үүрэг хүлээгчдийн хүлээх чиг үүрэг Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Боловсролын ерөнхий, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиудад тодорхой тусгагдсан. MNS 6782:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага", MNS 6781:2019 "Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага" болон MNS 6799:2019 "Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага" стандартуудад эрүүл, аюулгүй орчинд хэрхэн сурч, амьдрах, чанартай хоол тэжээл, цэвэр ус, эрүүл мэнд, ариун цэврийн үйлчилгээ авах талаар тусгасан. Эдгээр стандартуудад тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд судлахад дараах үр дүн гарсан.

Суралцагчдын өгсөн хариултаас харахад 13-17 насны хүүхдүүдийн зонхилох буюу 73.4 хувь нь сургуулийн орчинд нь аюулгүй байдал нь алдагдаагүй гэж хариулсан нь дээрх стандартуудыг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагууд анхаарч байгаагийн илрэл юм. Харин 3.3-8.1 хүртэлх хувьд анги танхим, сургуулийн коридор, биеийн тамирын танхим, ариун цэврийн байгууламж орчимд аюулгүй байдал алдагдсан нь анхаарал хандуулах хэрэгтэйг харуулж байна. Зарим сургууль, дотуур байрны орчин бүрэн хашаалагдаагүй, ногоон байгууламж, спортын талбай стандартын шаардлагад нийцэлгүй, гэрэлтүүлэг муу, авто замын тэмдэг тэмдэглэгээ шаардлага хангахгүй байгаа нь суралцагчдын эсэн мэнд амьдрах эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл болж байна. Мөн зарим сумдын сургуулийн эргэн тойрны 150 метр газарт эвдэрсэн, ашиглалтгүй, хаалга цонх нь тоногдсон барилга байгууламж байгаа нь хүүхдийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй талаар чанарын ярилцлагын үеэр багш нар дурдаж байв. Хотын сургуулийн хүүхдийн 40.0 гаруй хувь нь ямар нэг тээврийн хэрэгслээр сургуульдаа ирж очиж байгаа ч дөнгөж 4.0 орчим хувь нь сургуулийн автобусаар үйлчлүүлж байна.

Сургууль, дотуур байрны эрүүл ахуй, сурагчдад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ, хоол хүнсний ариун цэврийг стандартын түвшинд хүргэж сайжруулах шаардлагатай. Сургууль, дотуур байранд хүүхдүүд цэвэр усыг хүртээмжтэй хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Биеийн тамирын хичээлийн танхимыг өндөр ачаалалтай ашиглахаас өөр хувилбаргүй болсон сургуулиуд хүүхдийн нас хөгжлийн онцлогт нь нийцүүлэн хичээлийн хуваарийг гаргах шаардлагатай болжээ. Ингэснээр биеийн тамирын зааланд бэртэж гэмтэх, дээрэлхэлтэд өртөх эрсдэлийг бууруулж болно. Биеийн тамирын хичээлд орохдоо эмэгтэй, эрэгтэй сурагчдын хувцас солих тус тусдаа өрөөтэй байх стандарт шаардлагыг хангахад сургуулийн зураг төслөөс эхлэн анхаарах шаардлагатай нь ажиглагдав.

Тухайлбал, нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих, ундны цэвэр усаар тогтмол хангах, эцэг, эхийн уулзалтын өрөөг байгуулах зэрэгт анхаарах нь чухал байна.

Жендэрийн асуудлаар сургууль, дотуур байранд бие засах газрыг охидын сарын тэмдгийн үед ариун цэврийг бүрэн сахих, хувийн нууцаа хадгалах боломжоор хангаж, стандартын дагуу засаж тохижуулах хэрэгцээ тулгамдаж байна. Дотуур байранд нэг гэр бүлийн өөр өөр хүйсийн хүүхдүүдийг хамтад нь оруулахдаа шилжилтийн насны онцлогийг харгалзах нь зүйтэй.Сургууль, дотуур байруудад гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах хэрэгтэй байна. Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг стандартын дагуу боловсруулж, хэрэглэгчид буюу суралцагчид, багш ажилтнуудад таниулсан сургуулийн тоо цөөн байна. Сургууль, урлаг соёлын танхим, дотуур байранд  орц гарцын тэмдэглэгээг бүрэн хийж суралцагчдад таниулах, гамшгийн үед авран хамгаалах үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болохуйц байдлаар сургуулийн гадаад талбайг засаж тохижуулах шаардлагатай байна.

# 3. ХӨГЖИХ ЭРХ

## Хүүхдийн хөгжих эрхийн талаарх хууль эрх зүйн орчин ба өнөөгийн байдал

Өсвөр насны хүүхдүүд бие бялдар, бэлгийн бойжилт, оюун санаа, сэтгэл хөдлөлийн хувьд хурдацтай өөрчлөгддөг онцлогтой. Энэ үедээ хөгжих эрхээ хэрхэн хангасан нь тухайн хүүхдийн ирээдүйн ажил амьдралд ихээхэн нөлөөтэйгөөс гадна улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдолтой. ХЭК-д хүүхдийн хөгжих эрхийг онцлон анхаарч боловсрол эзэмших, чөлөөт цагаа өнгөрүүлэх, соёл урлаг, урлан бүтээх үйл ажиллагаанд хамрагдах эрхийг хүүхэд бүрд тэгш эдлүүлэх үүргийг гишүүн улс орнууддаа өгсөн байдаг. Монгол Улсын хувьд Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал,харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил[17] гэж тодорхойлжээ. Хүүхэд хөгжих эрхээ амралт, чөлөөт цагаараа тоглож наадах, хүүхдийн зуслан, сувилалд амрах, өөрийн хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэрэг хэлбэрээр эдлэх[18] боломжтой. Хүүхдийн хөгжих эрхийг хангахад боловсролын байгууллагаас гадна хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны засаг дарга нар, хуулийн этгээд, эцэг, эх, асран хамгаалагч хэрхэн оролцохыг Хүүхдийн эрхийн тухай хуулиар тогтоожээ.

15-аас дээш насныхны хувьд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиар асуудал, бэрхшээлийг даван туулах чадамж, бие бялдар, оюун санаа, сэтгэлгээ, амьдрах ур чадвар, харилцаанд нь гарч байгаа ахиц өөрчлөлтийг нь дэмжсэн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах[19] эрх нь үүсдэг. Тэдэнд зориулсан хөгжлийн үйлчилгээ нь сайн дурын болон хүмүүнлэгийн ажил, залуучуудын хөгжлийн төв, ТББ болон залуусын өөрсдийн санаачилгаар хэрэгжих гэх мэт хэлбэрүүдтэй байхаар энэ хуульд тусгагджээ.

Хүүхдэд зориулсан хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааг сургуульд түшиглэн явуулахад Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/659 тушаалаар батлагдсан “Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлал”-ыг мөрдөн явуулж байна. Мөн хүүхдийн оролцоонд тулгуурлан суралцагчдын танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшлийн хөгжлийг дэмжих, хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэл болгон БШУ-ны сайдын 2022 оны А/288 дугаар тушаалаар “Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийг мөрдөн явуулж байна.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан үндэсний болон орон нутгийн байгууллага хүүхдийн ордон, хүүхэд хөгжлийн төв, хүүхдийн

17 Хүүхдийн эрхийн тухай хууль. 6.1

18 Хүүхдийн эрхийн тухай хууль. 6.2

19 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. 4.1.2

зуслангууд ажиллуулдаг. Улсын хэмжээнд хүүхдийн хөгжлийн ордон 15, хөгжлийн төв 6, хүүхдийн театр 4, үйл ажиллагаа явуулж, 13 аймаг, 3 дүүрэгт 4-25 төрлийн дугуйлан хичээллэж, 2022 онд эдгээр байгууллагуудаар дамжуулан хөгжлийн үйлчилгээнд 61050 хүүхэд хамрагдсан байна.[20]

Ажил мэргэжлийн чиг баримжаа олох, хөдөлмөрийн харилцаанд оролцох, эдийн засгийн хувьд бусдаас бага хамаарах зэрэг зорилгоор сурах боломжоо алдахгүйгээр, хөнгөн ажил хөдөлмөр эрхлэх нь өсвөр насны хүүхдийн хөгжлийг дэмждэг. Сүүлийн жилүүдэд хүүхдүүд зуны амралтаараа цалин хөлстэй ажил хийх сонирхол нэмэгдэж байгаа нь хууль эрх зүйн шинэ зохицуулалтын хэрэгцээ бий болгосон. “Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход саад учруулахгүй нөхцөлд 13-15 насны хүнийг хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөлтэйгөөр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлж болно” гэсэн заалт Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсаны дагуу Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/123 тушаалаар 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тогтоосон. Энэ нь “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан, насны онцлогт тохирсон хөдөлмөрийн нөхцөлөөр хангах, хичээлийн үед долоо хоногт 15 цагаас илүүгүй хугацаагаар хичээлийн улирлын амралтын үед долоо хоногт 20 цагаас илүүгүй хугацаагаар ажиллуулах” нөхцөл юм. “Урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд өсвөр насны хүүхдийг оролцуулахаар хууль ёсны төлөөлөгч/эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн бичгээр гаргасан зөвшөөрөл, ажиллах цаг, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг үндэслэн хүүхдийн эрхийн улсын байцаагч тухай бүр зөвшөөрөл олгосон бол хөдөлмөр эрхлүүлж болно” гэсэн зохицуулалт журамлагджээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т заасанаар байгууллага бүрд ажиллах эцэг, эхийн зөвлөл нь ажиллагсдынхаа хүүхдийн хөгжил, хамгааллын төлөө олон ажил санаачлан хийх боломжтой болсон. Үүнд хүүхдийн зусланд амруулах, авьяас чадварыг нь хөгжүүлэх төлбөртэй сургалт, хөтөлбөрийн зардлыг хариуцах зэрэг ажлууд байж болох юм.

Мэдээллийн технологийн хөгжлийг дагаад дэлхий даяар өсвөр насны хүүхдүүдийн цахим орчныг мэдээлэл авах, тоглох зэргээр чөлөөт цагаа өнгөрөөх хэрэгсэл болгон ашиглах нь нэмэгдэж байна. Монгол Улсад өсвөр насныхны 99 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд интернэт орчинд холбогдсон нь бусад насны хүн амын бүлгээс хамгийн их цахим хэрэглээтэй гэж гарсан бөгөөд тэд өдөрт 7-9 цагийг нийгмийн сүлжээнд өнгөрөөж байна.[21]

20 ГБХЗХГ 2022 оны Тайлан

21 Харилцаа холбооны зохицуулах хороо. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал. 2022 он

### 3.1 Сургуулийн орчин дах хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээ

Тус судалгааны асуулгад хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээ, спорт урлагийн арга хэмжээнд оролцох, амралт чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх боломж, нөхцөл ямар байгааг 13-17 насны хүүхдүүдээс тодруулахыг зорьсон.

Хүүхдүүдийн хариултаас үзэхэд, тэдний хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан байдал хотын болон хөдөөгийн сургуултудад ойролцоо буюу 13-17 насны хотын хүүхдүүдийн 58.9 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 58.8 хувь нь хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж чаджээ (Зураг 3.1). Хөгжлийн үйлчилгээнд хотын болон хөдөөгийн сургуулийн хүүхдүүдийн хамрагдалт ойролцоо байгаа бол эмэгтэй сурагчдын хамрагдалт эрэгтэй сурагчдаас 5.8 хувиар илүү байна.

*Зураг 3.1. Сургуулийн орчинд хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан байдал, хүйсээр, байршлаар*




### 3.2 Хөгжлийн үйлчилгээний хүртээмж

*Хүснэгт 3.1. Сургуулийн орчинд хичээлээс гадуурх хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан байдал, насны бүлгээр*

| | 13 нас | 14 нас | 15 нас | 16 нас | 17 нас |
|---|---|---|---|---|---|
| БҮГД | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тийм | 53.8 | 60.7 | 57.7 | 59.5 | 60.0 |
| Үгүй | 46.2 | 39.3 | 42.3 | 40.5 | 40.0 |

Хичээлээс гадуур үйл ажиллагаа явуулах зай талбай, анги танхим байхгүй гэж хотын сурагчдын 34.6 хувь, хөдөөгийн сурагчдын 34.3 хувь нь хариулсан. (Зураг 3.2). Сургуулийн орчинд хийсэн ажиглалтаас харахад зарим сургуулийн хувьд суралцагчдын тоо нь сургуулийн даацаас хэтэрснээс хичээлээс гадуур дугуйлан, клуб ажиллуулах өрөө танхимын хүрэлцээгүй байдал үүсгэж байна. Мөн зарим сургуулийн хувьд барилга байгууламж, халаалтын систем хуучирч муудсаны улмаас өвлийн улиралд ашиглах боломжгүй болдог нь хичээлээс гадуур дугуйлан, секц, клуб ажиллуулахад

бэрхшээл учруулдаг талаар багш нарын бүлгийн ярилцлагын үр дүнгээс дүгнэж болно.

Хүүхдүүд хөгжлийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа дараагийн нэг шалтгаан нь сургуулиас санал болгож байгаа үйл ажиллагааны нэр төрөл, хэлбэр агуулга нь суралцагчдын сонирхолд нийцдэггүйтэй (20.1 хувь) холбоотой байна.

*Зураг 3.2. Хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй шалтгаан, байршлаар*




## *3.3. Спортоор хичээллэх боломж*

Сургууль, дотуур байрны стандарт[22] [23]-д хүүхдүүд аюулгүй байдлыг нь хангасан спорт тоглоомоор тоглох боломжоор хангагдсан байх талаар тусгагдсан байдаг.

22 MNS 6782:2019. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага

23 MNS 6781:2019. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага

*Зураг 3.3. Сургуулийн орчим ямар нэг спортоор хичээллэх, тоглох боломж*




Зураг 3.3-аас харахад хүүхдүүдийн 31.0 хувь нь тэдний сурч буй сургууль спорт тоглоомын талбайгүй, харин 31.5 хувьд нь сургуулийн гадаа спортоор хичээллэх, тоглох боломж хязгаарлагдмал гэсэн бол 15.3 хувь нь тоглоомын талбайд тоглуулдаггүй гэсэн хариултуудыг өгчээ. Гадаа тоглох сонирхолгүй, завгүй хүүхдүүд нийлээд 14.8 хувийг эзэлж байна.

## 3.4. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны төрлүүд

Чанарын судалгаанд оролцсон багш нарын өгсөн мэдээллээс үзэхэд дараах хичээлээс гадуурх үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Спортын чиглэлээр: гимнастик, шатар, теннис, сагс, гар бөмбөг, хөл бөмбөг, 100 буудалт даам.
2. Урлагийн чиглэлээр: гитар, бүжиг, уран зураг, цаасан хайчилбар, бишгүүр хөгжим, бүжиг.
3. Соёл, ёс заншлын чиглэлээр: бийрэн бичлэг, уламжлалт тоглоом, ёс заншлыг ойлгуулах клуб, монгол хэл, уран зохиолын дугуйлан.
4. Гадаад хэлний чиглэлээр: Англи хэл, англиар яригчдын клуб.
5. Шинжлэх ухаан, техник сэтгэлгээг хөгжүүлэх чиглэлээр: “Би инженер” дугуйлан, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх дугуйлан.
6. Байгаль орчны хамгаалал чиглэлээр: эко клуб цэцэгчдийн клуб.
7. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр: “өсвөрийн цагдаа” клуб, өсвөрийн санхүүчид, өсвөрийн номын санч. Хувь хүний хөгжлийн чиглэлээр: мэтгэлцээний клуб, сурагчийн парламент, Авлигатай тэмцэх газар (АТГ) -тай хамтарсан шударга ёсны клуб, номын клуб.

*Нийслэлийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Манай сургуульд "Улаан загалмай", "Өсвөрийн цагдаа", "Сурагчдын өөрөө удирдах зөвлөл", "Загварын клуб", "Охид, хөвгүүдийн зөвлөл" гэх мэт нийт 13 клуб, зөвлөлүүд бий. Эдгээр клубүүдийн үйл ажиллагааг ихэвчлэн анги даасан багш нар хариуцаж ажилладаг. Хүүхдүүд нь их идэвхтэй сайн оролцдог.*

### *3.5. Хүүхдийн ордон, хөгжлийн төвийн үйлчилгээ*

13-17 насныхны 27.3 хувь нь хөгжлийн ордон, төвүүдээс явуулж буй сургалт, дугуйланд хамрагддаг. Харин тус үйлчилгээнд хамрагдаагүй шалтгааныг үзэхэд 20.4 хувь нь сонирхолд нийцсэн секц, клуб, сургалт, дугуйлан байдаггүй, 19.1 хувь нь завгүй байсан бол 10.5 хувь нь төлбөрийн чадамжгүйгээс шалтгаалжээ. Эдгээр ордон, төвүүдээс явуулж буй үйл ажиллагаанд эмэгтэй сурагчид илүү хамрагдсан байна.

Хүүхдийн хөгжлийн ордон, төвүүдэд урлаг, спорт зэрэг төрөл бүрийн секц, клуб, сургалт, дугуйлан ажиллуулдаг бөгөөд эдгээр үйл ажиллагааг төсвөөс санхүүжүүлэх асуудал хязгаарлагдмал тул орон нутгийн иргэдийн төлбөрийн чадварт нийцүүлсэн зардлаар хүүхдүүдийг хамруулах нь түгээмэл байна.

*Зураг 3.4. Сүүлийн 12 сарын хугацаанд Хүүхдийн хөгжлийн ордон, хүүхдийн хөгжлийн төвөөс явуулдаг урлаг, спортын ямар нэгэн секц, клуб, сургалт, дугуйланд хамрагдаагүй шалтгаан, хүйсээр*



*Хөдөөгийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Малаа хариулуулах, дүү нарыг нь асруулах гэх мэтээр эцэг, эхчүүд хүүхдийн сурах, хөгжих эрхийг зөрчих тохиолдлууд байдаг.*

### *3.6. Ном унших дадал*

Хүүхдийн хөгжлийн чухал бүрэлдэхүүнд ном унших дадал ордог. Өсвөр үеийнхний 78.2 хувь нь өнгөрсөн сард ямар нэгэн ном уншсан байв. Ингэхдээ тэдний тал орчим хувь нь ном уншихад 1-5 цагийг зарцуулжээ.

*Зураг 3.5. Өнгөрсөн нэг сарын хугацаанд ном уншихад зарцуулсан дундаж хугацаа, цагаар*




Өөрт хэрэгтэй мэдээллээ хүртээмжтэй сувгаар, тогтмол авах нь хүүхдийн чадавхад нөлөөлж, хөгжих боломжийг нь нэмэгдүүлдэг. Хүүхдүүдийн 57.9 хувь нь нийгмийн сүлжээ, интернэтээс мэдээллээ авч байгаа гэж хариулсан.

*Зураг 3.6. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж*



Хотын сурагчид нийгмийн сүлжээ, интернэтээс 63.3 хувь нь мэдээлэл авдаг бол хөдөөгийн сурагчид 13.0 хувиар бага буюу 50.3 хувь нь мэдээлэл авч байна.

*Зураг 3.7. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, байршлаар*




Эмэгтэй сурагчдын (64.5 хувь) дунд нийгмийн сүлжээ, интернэтээс мэдээллээ авах нь эрэгтэй сурагчдаас (55.5 хувь) 10.0 орчим хувиар илүү байна. Эрэгтэй сурагчдын найз нөхөд, сургууль багш нар, гэрийнхнээсээ мэдээлэл авах нь эмэгтэй хүүхдүүдээс 3.2 хувиар бага байв.

*Зураг 3.8. Хүүхдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, хүйсээр*



Хүүхдийн нас ахих тутам гэрийнхнээсээ мэдээлэл авах байдал нь буурч, нийгмийн сүлжээ, цахим орчноос авах нь нэмэгдэж байна.

*Зураг 3.9. Хүүхдүүдийн хандаж буй мэдээллийн эх сурвалж, насаар*




## *3.7. Зуны амралт*

Суралцагчдын хувьд зуны амралтын хугацааг хэрхэн өнгөрүүлж буйг тодруулсан. Хүүхдүүдийн 35.6 хувь нь зуны амралтыг гэртээ дуртай зүйлээ хийж амарсан бол 23.6 хувь нь мал маллах, цагаан идээ боловсруулах байдлаар өнгөрөөсөн байна. Өрхийн үйлдвэрлэлд оролцох нь уламжлал болсон бөгөөд ихэвчлэн цалин хөлсгүй ажил юм. Энэ төрлийн ажилд хөдөөгийн таван хүүхэд тутмын хоёр (43.3 хувь), хотын 6 хүүхэд тутмын 1 (17.9 хувь) нь оролцсон байна.

Нийт сурагчдын 12.5 хувь нь зуны амралтаараа цалинтай ажил хөдөлмөр эрхэлсэн. Эрэгтэй сурагчдын 16.1 хувь, эмэгтэй сурагчдын 9.2 хувь нь зуны амралтаараа цалинтай ажил эрхэлсэн байна. (Зураг 3.10).

*Зураг 3.10. Зуны амралтыг өнгөрүүлж буй байдал, хүйсээр*




## ДҮГНЭЛТ

Өсвөр насны хүүхдийн хөгжих эрхийг Хүүхдийн эрхийн тухай, Залуучуудын хөгжлийн тухай болон Боловсролын багц хуулиуд, тэдгээрт холбогдох журам, аргачлал, стандартуудаар дэмжиж байна. Ерөнхий боловсролын сургуулиуд болон аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллагуудын дэргэдэх Хүүхдийн хөгжлийн ордон, Залуучуудын хөгжлийн төвүүд хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагаа зохион байгуулж байна.

Сургуулийн орчинд хичээлээс гадуур хэрэгжүүлж буй хүүхдийн хөгжлийн үйл ажиллагаанд 13-17 настай хүүхдүүдийн 58.9 хувь нь хамрагдаж байна. 16-17 настай хүүхдүүдийн хамрагдалт бусад насны бүлгийн хүүхдүүдээс илүү байв.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд сургуулийн анги танхим, зай талбайн хүрэлцээгүй байдал мөн нөлөөлж байна. Сургуулиас гадуур хүүхдийн хөгжлийн ордон, төвүүдийн үйл ажиллагаанд төлбөрийн чадваргүй, гэр орноосоо хол амьдран суугаа зэргээс болж оролцож чадахгүй хүүхдүүд

байна. Мөн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, сургалтуудын агуулга, арга зүйн хувьд сонирхол хэрэгцээнд нийцүүлэх шаардлага байна. Ялангуяа, эрэгтэй хүүхдүүдийн хэрэгцээ, сонирхолд нийцэх хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх нь зүйтэй.

Орчин үеийн өсвөр насны хүүхдэд сургалт, нөлөөллийн ажлыг телевиз болон сонин хэвлэлээр дамжуулан өгөх нь оновчтой биш байна. Тэд мэдээллийг цахим сүлжээ, интернэт орчноос авахыг чухалчилж байна. Өсвөр насны хүүхдүүдийн 60.0 орчим хувь нь нийгмийн сүлжээ, интернэтээр дамжуулж хэрэгтэй мэдээллээ авч байна. Хотын хүүхдүүд энэ талаар хөдөөгийн хүүхдүүдээс 13 пунктээр илүү байна. Хүүхдийн нас ахих тусам нийгмийн сүлжээ, интернэтээс мэдээлэл авах нь нэмэгдэж, гэр бүлийн гишүүдээсээ авах нь буурч байна.

Найз нөхдөөсөө мэдээлэл авах нь сургууль болон эцэг, эх, гэр бүлийнхэндээ ханддаг хүүхдүүдээс өндөр байна. Хүүхдийн тусламжийн 108 утаснаас үзүүлдэг нөхөн үржихүйн боловсрол, сэтгэл зүйн хямралыг даван туулах зөвлөгөө авах боломжийг өсвөр насныхан бага ашиглаж байна.

Өсвөр насныхны гадаа тоглох сонирхол анги ахих тусам буурч байна. Энэ нь тэдний цахим хэрэглээ нэмэгдэж буйтай холбоотойгоос гадна гадаа тоглох орчин, зориулалтын дагуу тоноглосон спорт заал, танхим, урлан бүтээх төвд чөлөөт цагаа өнгөрүүлэх  боломж нөхцөл бүрдээгүйтэй холбоотой байж болох юм.

13-17 насны хүүхдүүдийн 6.4 хувь нь гадаа тоглох завгүй гэжээ.

Хоёр хүүхэд тутмын нэг нь зуны амралтаараа хөдөлмөр хийж өнгөрөөжээ. Хөнгөн ажил хийх нь өсвөр насны хүүхдийн хувьд өөрийгөө хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, санхүүгийн боловсролоо дээшлүүлэхэд ач холбогдолтой.

# 4. ОРОЛЦОХ ЭРХ

## Хүүхдийн оролцох эрхийн талаар өнөөгийн байдал

Хүүхдийн эрхийн конвенцод зааснаар өсвөр насныхан өөрсдийн амьдрал болон нийгэмд хамааралтай шийдвэр гаргах үйл явцад оролцох, нөлөөлөх эрхтэй. Тус конвенцын 12 дугаар зүйлд “Оролцогч улсууд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвартай хүүхдэд өөрт нь хамааралтай бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүүхдийн нас, төлөвшлийн дагуу баталгаажуулж, хүүхдийн үзэл бодлыг зохих ёсоор үнэлнэ" хэмээн заасан.

Монгол Улсын хувьд Конвенцын энэ заалтыг хэрэгжүүлж хүүхдийн оролцоог хангахын тулд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг бүхэлд нь хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрхэд зориулж дараах оролцох эрхийг хүүхэд бүрт эдлүүлэхээр заасан. Үүнд:

1. Хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох,
2. Эвлэлдэн нэгдэх,
3. Өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох;
4. Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, шаардах,
5. Өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх,
6. Хуульд заасан үндэслэл журмын дагуу өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил, үйлчилгээний хөлс, урамшуулал авах зэрэг байна.

Өсвөр насны хүүхдийн оролцох эрхийг хангахад ЕБС болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн байгууллага үүрэг хүлээнэ. ЕБС-ийн хувьд сургуулийн удирдлага, зөвлөл, нийгмийн ажилтан, багш нар суралцагчийн оролцох эрхийг хангаж, тэднийг шийдвэр гаргалтад оролцуулах, санаачилсан оролцооны байгууллагууд, сайн дурын ажлыг нь дэмжих үүрэг хүлээдэг. Харин хүүхэд гэр бүлийн хөгжлийн байгууллага нь хүүхдийн оролцооны байгууллагуудыг бүртгэж мэргэжил арга зүйн удирдлагаар хангадаг. Хүүхдийн оролцооны байгууллагууд нь хүүхдээс гарсан санал, санаачилгыг шийдвэр гаргагчдад хүргэх ажлыг үндэсний болон орон нутаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулах ажлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө байгууллагууд хэрэгжүүлдэг.

Хүүхдийн оролцооны сургууль, дотуур байр, хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө байгууллагууд төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг боловч тэдэнд танхим, үйл ажиллагаанд зардал, эцэг эх, багш, сургуулийн захиргаа, хүүхдийн хөгжлийн төлөө байгууллагын дэмжлэг хэрэгтэй байна.

Олон улсын түвшинд сайн дурын ажлыг иргэний боловсролын сургалтын нэг хэсэг гэж үздэг үзэл баримтлал Боловсролын ерөнхий хуульд хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох нь

суралцагчийн эдлэх ёстой эрхүүдийн нэг[24] гэсэн агуулгаар тусаад байна. Мөн Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиар өсвөр насныхныг сайн дурын ажилд олон хэлбэрээр оролцох сонголттой болгожээ.

### *4.1. Өөрт хамааралтай шийдвэр гаргалтад оролцох*

Хүүхдийн оролцох эрхийн нийтлэг 4 эрхийн хэрэгжилт ямар байгааг танилцуулъя. Эхлээд өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоо ямар байгааг харцгаая. Судалгааны үр дүнгээс харахад Хэний ч оролцоогүй өөрөө шийдвэр гаргасан хүүхдүүдийн хувь 35.3 хувь

*Хүснэгт 4.1. Өсвөр насныхны шийдвэр гаралтад оролцсон байдал, хувиар*

| Шалгуур үзүүлэлтүүд | Хувь |
|---|---|
| Хэний ч оролцоогүй өөрөө шийдвэр гаргасан. | 35.3 |
| Зарим үед насанд хүрсэн хүний дэмжлэгийг авч шийдвэр гаргаж байсан | 40.8 |
| Би өөрийн саналыг насанд хүрсэн хүнд хэлж шийдвэр гаргуулсан. | 9.9 |
| Надаас асуулгүй насанд хүрсэн хүн миний өмнөөс шийдвэр гаргасан. | 3.5 |
| Хариулж мэдэхгүй байна | 10.5 |

Хүйсийн хувьд харьцуулбал, насанд хүрсэн хүний зөвлөмжийг эмэгтэй сурагчид тусгах нь илүү байгаа бол эрэгтэй сурагчдын хувьд өөрөө бие даан шийдвэр гаргах талаар давуу байна.

*Зураг 4.1. Хүүхэд өөрийн хамааралтай асуудлаар шийдвэр гаргалтад оролцсон байдал, хүйсээр*




### *4.2. Санал асуулгад оролцох*

Санал асуулга явуулах нь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэрэгслүүдийн нэг юм. Нэргүй, нууцлал хадгалсан нөхцөлд санал асуулга

24 https://legalinfo.mn/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Боловсролын ерөнхий хууль. 10.1.7

явуулах нь хүүхдүүдэд үзэл бодлоо илэрхийлэхэд дөхөмтэй болгодог. Хүүхдүүдийн 40.0 орчим хувь нь сургуулийн орчинд хичээлээс гадуур явуулах үйл ажиллагааны талаарх санал асуулгад оролцсон байна. 9-р ангийнхны дунд санал асуулгад оролцсон хүүхдийн хувь хамгийн өндөр буюу 44.2 хувь байгаа бол 11-р ангийнхны хувьд хамгийн бага буюу 35.1 хувьтай байна.

*Зураг 4.2. Сургуулийн орчинд хичээлээс гадуур явуулах үйл ажиллагааны талаарх санал асуулга явагдсан байдал, ангиар*




### *4.3. ИТХ-ын шийдвэрт нөлөөлөх*

Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөлтөд оролцож санал бодлоо илэрхийлэх нь зөвхөн гэр бүл, сургуулийн орчноор хязгаарлагдахгүй оршин суугаа засаг захиргааны нэгжид буй Иргэдийн төлөөлөгчдийн хуралд дуу хоолойгоо өргөж, улмаар шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжийг Хүүхдийн эрхийн тухай хуулиар олгодог. Энэ боломжийг хүүхдүүд хэр эдэлж буйг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө байгууллагаас тусгай шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг. Тухайн шатны хурал нь хүүхэд залууст зориулсан төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлэх, тоглоомын талбай, спорт цогцолбор, номын сан, хүүхдийн хөгжлийн төв зэрэг бүтээн байгуулалтыг хийх үүрэгтэй. Эдгээр бүтээн байгуулалтыг төлөвлөхдөө хүүхдийн саналыг хэрхэн тусгасныг энэ шалгуур үзүүлэлтээр хэмжих учиртай. Өсвөр насныхны 80.0 орчим хувь нь амьдран суудаг сум, аймаг, дүүргийн, Иргэдийн төлөөлөгчийн хурлаас хүүхдүүдийн өгсөн саналын дагуу тэдэнд зориулсан ямар нэгэн төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил хийх шийдвэр гарсан талаар мэдээгүй, сонсоогүй гэсэн хариулт өгчээ.

*Зураг 4.3. Оршин суугаа газрын ИТХ-аас хүүхдүүдийн саналын дагуу аливаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байдал, хүйсээр, байршлаар*

А. Хүйсээр




Б. Байршлаар




## *4.4. Хүүхдийн оролцооны байгууллагууд*

Хүүхдийн оролцоог хангах бусад хэлбэрт хүүхдүүд эвлэлдэн нэгдэж бүлэг, клуб, хамтлаг зэрэг хүүхдийн оролцооны байгууллага байгуулах арга хэмжээнүүд ордог. Судалгаанд оролцсон багш нарын өгсөн мэдээллээс харахад сургуулиудын хувьд дараах хүүхдийн оролцооны байгууллагууд байдаг. Үүнд:

- Сурагчийн парламент;
- Скаутын хөдөлгөөн;
- Өсвөрийн улаан загалмай;
- Хөгжлийн бэрхшээлтэй болон амьдрал хүнд хүүхдүүдэд дэмждэг, тусламж үзүүлэх клуб;
- Ангийн дарга нарын зөвлөл, хөвгүүдийн зөвлөл, охидын зөвлөл зэрэг байна.

Багш нарын өгсөн ярилцлагаас харахад сургууль дээр зохиогддог ажлуудад идэвхтэй оролцдог, хүүхдийн оролцооны байгууллагуудад тогтмол хамрагдах сонирхолтой хүүхдүүд олон байна. Гэвч хүүхдийн оролцооны байгууллагууд цугларах өрөө танхимын хүрэлцээгүй байдал үйл ажиллагааны зардлыг нь хэн дэмжих нь тодорхойгүй учраас тогтмол ажилладаг нь цөөхөн гэжээ.

Харин хүүхдүүд өөрсдийнхөө оролцоог хэрхэн дүгнэснийг зураг 4.4-өөс харж болно.

*Зураг 4.4. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоо, хүйсээр, байршлаар*




Өөрсдөө санаачлан зохион байгуулж оролцдог хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, бүлэг, хамтлаг, клубийн үйл ажиллагаанд сүүлийн 12 сарын хугацаанд оролцсон эсэх талаар тодруулахад 60.0 орчим хувь нь "Үгүй" гэж хариулжээ.

Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, бүлэг, хамтлаг, клубийн ажиллагаанд хамгийн идэвхтэй оролцдог нь 11-р ангид суралцагчид (48.7 хувь) байх бөгөөд төгсөх 12-р ангид тэдний оролцоо 45.5 хувь хүртэл буурч байгаа нь ЭЕШ-д бэлтгэх үүднээс бусад асуудалд зарцуулах цаг хомс болдогтой холбоотой гэж дүгнэлээ.

*Зураг 4.5. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаанд оролцох оролцоо, ангиар*




## 4.5. Сайн дурын ажил

Хүүхдийн оролцоог бодитойгоор эдлүүлэх нэг хэлбэр бол сайн дурын ажилд оролцуулах юм. Сайн дурын ажил нь иргэний боловсролын

нэг хэсэг бөгөөд өсвөр насандаа сайн дурын ажилд оролцож байсан хүүхдийн нийгмийн харилцааны чадвар, өөртөө итгэх итгэл дээшилдэг нь судалгаагаар нотлогдсон байдаг.[25]

*Зураг 4.6. Сайн дурын ажилд оролцсон байдал, хүйсээр, байршлаар*




Өсвөр насныхны сайн дурын ажилд оролцсон байдал 45.3 хувьтай байна. Хөдөөгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс сайн дурын ажилд оролцох нь 9.0 хувиар өндөр байна.

Сүүлийн жилүүдэд сурагчдын дунд сайн дурын ажилд хамт олноороо оролцох сонирхлын бүлгүүд бий болж төрөл бүрийн сайн үйлсийн аян өрнүүлж байгааг багш нар ярилцлагын үеэр сайшаан дурдсан. Сайн дурын болон хүмүүнлэгийн үйл ажиллагаануудын жишээ татахдаа өсвөрийн улаан загалмай, интеракт клуб, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд тусламж, дэмжлэг үзүүлэх аяны талаар багш нар тодорхойлон хэлж байсан.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсад өсвөр насны хүүхдийн оролцох эрхийг хангахад Хүүхдийн эрхийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулиуд үйлчилж байна.

Өсвөр үеийнхэн бусдын хэний ч тусламжгүй өөрөө шийдвэр гаргах хандлага их байгаа нь тэдэнд зөв сонголт хийхэд нь тустай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэхэд сургууль багш, эцэг, эх, асран хамгаалагчид ихээхэн анхаарах хэрэгтэй болж буйг харуулж байна. Хүйсийн хувьд, насанд

25 Special Representative of the Secretary-General on Violence against Children (2012). Tackling violence in schools: A global perspective bridging the gap between standards and practice.

хүрсэн хүний зөвлөмжийг эмэгтэй хүүхдүүд шийдвэр гаргахдаа тусгах нь арай илүү байж хариу нь их байна.

Хүүхэд өөрт хамааралтай асуудлаар санал бодлоо илэрхийлж шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжоо бүрэн эдэлж чадахгүй байгаа нь сум, аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлаас хүүхдүүдийн өгсөн саналын дагуу хүүхэд, залууст зориулсан ямар нэгэн төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын ажил хийх шийдвэр гарсан талаар дийлэнх нь сонсоогүй, мэдэхгүй гэсэн хариулт өгснөөс харагдаж байна.

Хүүхдийн оролцооны байгууллагууд сургууль, дотуур байр, хүүхэд гэр бүлийн хөгжлийн төлөө байгууллагуудыг түшиглэн ажиллаж байна. Гэвч тэдэнд цугларах байр танхим, үйл ажиллагааны зардлаас гадна эцэг, эх, багш, сургуулийн захиргаа болон хүүхдийн хөгжлийн төлөө байгууллагын дэмжлэг хэрэгтэй байна.

Хүүхдүүд Улаан загалмай, Скаут, Интеракт гэх мэт олон улсын хүмүүнлэгийн хөдөлгөөнд нэгдэх, өөрсдөө санаачлан бусдад туслах, оршин суугаа газартаа хувь нэмэр оруулах сайн үйлсийн аян өрнүүлж байна. Хүүхдүүдийн тал орчим хувь нь ямар нэг сайн дурын ажилд оролцсон нь сайшаалтай. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулиар суралцагчийн санаачилсан нийгэм хүмүүнлэгийн сайн дурын ажлыг сургууль багш нар дэмжих үүрэгтэйг хуульчилсан нь суралцагчдын дунд сайн дурын ажил цаашид улам өрнөнө гэсэн хүлээлт үүсгэж байна.

# 5. ХАМГААЛУУЛАХ ЭРХ

## Хүүхдийн хамгаалуулах эрхийн талаарх хууль эрх зүйн орчин ба өнөөгийн байдал

Өсвөр насанд шилжиж буй хүүхдүүдийн хувьд бэлгийн бойжилт, гэр бүл, сургуулийн орчны өөрчлөлт нь тэдэнд өсөлт дэвшлийг авчрахаас гадна шинэ эрсдэлийг дагуулдаг. Ялангуяа, энэ хугацаанд эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс хайр халамж бага, хараа хяналт сул, түр болон урт хугацаагаар эцэг, эхээсээ хол амьдрах нь хүүхдүүдэд учирч болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлдэг. Хүүхдийн хаана хэнтэй амьдарч байгаагаас гадна тэдний нас, хүйс, хот хөдөөгийн ялгаа, сургууль, дотуур байрны орчны аюулгүй байдал, хамгааллын үйлчилгээний хүртээмж зэрэг нь хүүхдийг эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс юм. Эрсдэлийг бууруулж, хамгааллын хүчин зүйлсийг нэмэгдүүлэхэд хууль эрх зүйн зохицуулалт чухал ач холбогдолтой. Өсвөр насны хүүхдийн хамгаалагдах эрхэд хамаарах хууль эрх зүйн заалтуудаас дурдвал:

- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 7.1-д “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй”;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2.6-д “Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодын болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно”;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 12.1.1-д суралцагч нь “аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дээрэлхэлт, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид, ээлтэй, аюулгүй, хамгаалагдсан орчинд суралцах” эрхтэйг заасан бөгөөд 13.1.3-т бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй байх, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх үүрэгтэйг тодорхойлсон байна;
- Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.8-д заасналар сургуулийн орчинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, боловсролын сургалтын байгууллагыг арга зүй, зохицуулалтаар хангах үүргийг аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтэст хариуцуулсан.

Боловсрол сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БШУЯ-ны зүгээс 2017-2022 онуудад дараах

дүрэм, журам, чиглэл, нийтлэг шаардлагуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- “Ерөнхий боловсролын сургуул, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”,
- “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”,
- “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”.

Багш нарын зүгээс бие махбодын шийтгэл хэрэглэхийг хориглосон хууль тогтоомжийг дэлхийн 86 улс орон гаргажээ. Монгол Улсын хувьд 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хуулийг батлахдаа хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэлийг боловсролын болоод нийгмийн бүх орчинд хориглосон. Багшийн ёс зүйн дүрэмд багш нарын зүгээс хүүхдэд бүх төрлийн хүчирхийлэл, бие махбодын шийтгэл үл хэрэглэх талаар нарийвчлан тусгасан. Эдгээр баримт бичгийн хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Хүмүүжлийн эерэг арга” сургалтад ерөнхий боловсролын сургуулийн багш, дотуур байрын багш нарыг хичээл заах, анги удирдах, хүүхэдтэй ажиллах алхам бүрдээ хүчирхийлэлгүй арга хандлагыг хэрэглэх, хүүхэд бүрийн хувийн болон насны онцлогийг харгалзан ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой хамруулжээ.[26]

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 142 болон 143 дугаар зүйлээр зохицуулж байна. Хуулиар хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжоор хориглосон хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийн хөдөлмөрийг мөлжлөгийн хэлбэрээр ашиглах, цалин хөлсийг шударга бусаар тооцож олгох, хүүхдийн нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулах зэрэг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрийг хүүхдээр эрхлүүлэхийг хориглосон. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хүүхдийн эрхийн улсын байцаагч болон хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122, А/123 тоот тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” болон “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”-д хяналт тавьж, мөрдүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр байцаагчдын хамтран хэрэгжүүлдэг ажиллагаануудын нэг нь хурдан морины уралдааны үеэр хүүхдийн аюулгүй байдлыг хангах, насны доод хязгаарыг хууль тогтоомжийн дагуу мөрдөж байгаа эсэх, хүүхдийг даатгалд хамруулсан эсэхэд хяналт шалгалт тавих байдаг.

Тус судалгаанд уралдаанч хүүхдийн насны асуудлыг шийдэхэд хүүхдийн санал бодлыг тандах зорилго бүхий 1 асуултыг оруулсан. Асуултын хариултад

26 https://www.meds.gov.mn/post/105096

уралдаанч хүүхдийн  насны хязгаарыг хэд хэдэн бүлгээр оруулснаас гадна робот буюу хиймэл хүнээр унуулах хувилбарыг оруулсан.

Хурдан морь уралдуулах зэрэг хүүхдэд өндөр эрсдэлтэй хөдөлмөрөөс хүүхдийг хамгаалахаас гадна зарим төрлийн хөнгөн ажлыг хүүхдэд тохирсон орчин нөхцөлд, хичээл сургуульд нь саад болохгүйгээр цөөн цагаар хийлгэх нь хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх арга хэмжээ болдог. Иймээс Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгаар 13-15 насны хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлтэйгөөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд хөнгөн ажил эрхлүүлэх, 15 нас хүрээгүй хүүхдийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулах бол өөрөөс нь болон эцэг, эх, асран хамгаалагч, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвшөөрлийг тухай бүрд нь авна" гэсэн заалтыг тусгаад байна. Хуулийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны  А/123 тушаалаар "13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг тогтоох тухай" журам, мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 91.4-т заасны дагуу "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Соёл урлагийн газрын даргын хамтарсан 2022 оны А/242, А/76 тушаалаар баталсан.

Сүүлийн жилүүдэд өсвөр насны хүүхдийн цахим хэрэглээ эрс өссөн нь тэдний цахим гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Цахим орчинд хүүхэд гэмт хэрэг, зөрчилд өртөж байгаа шалтгаан, нөхцөлийг тодруулах зорилгоор улсын хэмжээнд санамсаргүй түүврийн аргаар хийсэн судалгаанд оролцсон 1699 хүүхдийн 16.4 хувь (280) нь цахим гэмт халдлагад өртөж байсан гэжээ. Цахим гэмт хэрэгт өртөж байсан гэх эдгээр хүүхдүүдийн 33.8 хувь нь мөнгө эд зүйлсээ залилуулсан, 19.0 хувь нь нууц үг хувийн мэдээллээ алдсан, 15.7 хувь нь зодуулж дээрэмдүүлсэн, 12.8 хувь нь садар самуунтай холбоотой гэмт хэрэгт өртөж байсан, 10.2 хувь нь гүтгүүлж, доромжлуулсан, 8.5 хувь нь дарамтад орсон гэж хариулжээ.[27]

Өөртөө болон найздаа тохиолдсон хүүхэд хамгааллын зөрчлийн талаар хүүхдүүд үнэ төлбөргүй дуудлага хэзээ ч хийж болох Хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдээлэх боломжтой. Дуудлагыг авсан утасны оператор яаралтай дуудлагыг хариу үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй байгууллага, ажилтанд шилжүүлэх, яаралтай биш бол зөвлөгөө мэдээлэл өгөх зэргээр шийдвэрлэдэг.  Суралцагчид өөртөө болон найздаа тохиолдсон дээрэлхэлт, хүчирхийллийн талаар сургуулийн нийгмийн ажилтандаа хандаж шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлуулж болохоос гадна сургуулийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авч болно. Мөн сургуулийн бус орчинд гарсан хэрэг зөрчлийн талаар сум, баг, хорооныхоо хамтарсан багт мэдээлж болно.

27 НҮБ-ын Хүүхдийн Сан. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. УБ. 2021. 26 х.

### *5.1. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлс*

Монгол Улсад үе тэнгийн болон цахим дээрэлхэлт, жендерт суурилсан хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, бэлгийн хүчирхийлэл зэрэг хүүхдийн эрхийн зөрчил өсвөр насныхны дунд ямар хэмжээнд байгааг тус судалгаатай нэг цаг хугацаанд зэрэгцүүлэн хийгдсэн ДЭМБ-ын судалгааны үр дүнгээс харагдлаа. Тухайлбал 13-17 насны хүүхдүүдийн 39.6 хувь нь сүүлийн нэг жилд ноцтой осол гэмтэлд өртсөн, 23.3 хувь нь бусдад зодуулсан, 28.3 хувь нь бусадтай зодолдсон, 26.9 хувь нь сургууль дээрээ бусдад дээрэлхүүлсэн, 17.9 хувь нь цахим дээрэлхэлтэд өртсөн дүн гарчээ. Хүүхдүүд гэр бүл, эцэг, эхтэйгээ хамт амьдарч байх нь тэдний хамгаалагдах эрхээ эдлэхэд эерэг нөлөө үзүүлдэг. Судалгааны мэдээлэл цуглуулах үеэр хотын хүүхдүүдийн 62.9 хувь, хөдөөгийн хүүхдүүдийн 42.4 хувь нь эцэг, эхийн хамт амьдарч байгаа гэж хариулжээ. Хөдөөгийн хүүхдийн 41.1 хувь нь бусад буюу эмээ, өвөө, хамаатан садан, таньдаг айлд эсхүл дотуур байранд амьдарч байна. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж малчдын эдийн засгийн чадавх дээшилснээр хот суурин газар, сумын төвд газар, байшин, орон сууц худалдан авч тэндээ хүүхдүүдээ үлдээж байгаа нь өсвөр насны охидыг хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг анги удирдсан багш нар бүлгийн ярилцлагын үеэр мэдээлж байв.

*Хөдөөгийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Миний даасан ангийн охин 16 настай. Өмнө нь дүү нартайгаа дотуур байранд амьдарч байхад нь санаа зовдоггүй байсан. Гэтэл энэ жил эцэг нь мянгат малчин болоод сумын төв дээр хашаа байшин худалдаж аваад хүүхдүүдээ оруулсан. Эцэг, эх нь өөрсдөө хөдөө малаа маллaдаг учраас хүүхдүүд хашаа байшиндаа хараа хяналтгүй байгаа. Гэрт нь элдэв улсууд цуглаад байна гэж хамар хашааных нь хүн хэлсэн тул би очсон. Охинтой үерхэж байгаа гээд цэргээс ирсэн залуу найзуудтайгаа гэрт нь хөзөр тоглоод сууж байсан. Би баахан хууль дүрэм яриад тэдгээр залуусыг гэрээс нь гаргасан."*

Нийт хүүхдийн 0.7 хувь нь сүүлийн 7 хоногт ганцаараа амьдарч байсан гэдэг хариулт өгсөн байна.

Хотын хүүхдүүдийн 17.0 хувь нь эх, 3.1 хувь нь эцгийн хамт амьдарч байсан бол хөдөөгийн хүүхдүүдийн 12.4 хувь нь тухайн долоо хоногт эхтэйгээ, 2.6 хувь нь эцгийн хамт амьдарч байв.

*Зураг 5.1. Сүүлийн 7 хоногт хамт амьдарч байсан хүн, байршлаар*




## *5.2. Үе тэнгийнхний дээрэлхэлт, бие махбодын шийтгэл*

Хүүхдийн эрхийг хамгийн их зөрчдөг хүмүүсээр үе тэнгийн хүүхдүүд нэрлэгдсэн байна. Өсвөр үеийнхний 37.4 хувь нь энэ хариултыг өгсөн бөгөөд хот, хөдөө болон жендэрийн хувьд их ялгаа гарсангүй.

Хүүхдэд үе тэнгийнхний дээрэлхэлтээс, бие махбодын шийтгэлээс ангид байх эрхийн тухай таниулах нь чухал байна. 4 хүүхэд тутмын 1 нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл зайлшгүй хэрэгцээтэй гэдэгтээ санал нийлж байгаа нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх соёл өсвөр насныхны дунд байгаагийн илрэл байх боломжтой юм. Эрэгтэй сурагчдын хувьд 33.6 хувь нь охидын 19.0 хувь нь бие махбодын шийтгэлийг зайлшгүй хэрэгцээтэй гэж үзжээ. Хөдөөгийн хүүхдүүд ийм төрлийн шийтгэлийг зөв гэж үзэх нь хотын үе тэнгийнхнээсээ 7.6 хувиар илүү байна.

*Зураг 5.2. Хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл шаардлагатай эсэх, хүйсээр, байршлаар*



### *5.3. Цахим орчны хүчирхийлэл*

Хүүхдүүд эхлээд нийгмийн сүлжээнд хэн нэгэнтэй танилцаж, харилцаа үүсгэснийхээ дараа тухайн хүнтэй биечлэн уулзаж хохирсон тухайгаа хуваалцаж байсныг багш нар дурдаж байв. Интернэт орчинд огт уулзаж байгаагүй хүнтэйгээ 2 хүүхэд тутмын 1 нь харилцаж байсан нь судалгаагаар тогтоогдов. Тэгэхдээ тэдний дийлэнх нь буюу 34-40 орчим хувь нь 1-2 удаа интернэт орчинд танихгүй хүнтэй харилцаж байсан байна.

*Зураг 5.3. Сүүлийн 12 сарын хугацаанд интернэт орчинд танилцсан хүнтэй биечлэн уулзсан байдал, хүйсээр*




*Хүснэгт 5.1. Сүүлийн 12 сарын хугацаанд огт уулзаж танилцаагүй хүнтэйгээ интернэт орчинд харьцсан байдал, ангиар*

| Үзүүлэлт | 8 анги | 9 анги | 10 анги | 11 анги | 12 анги |
|---|---|---|---|---|---|
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Огт харьцаж байгаагүй | 52.5 | 43.6 | 46.7 | 50.5 | 53.1 |
| 1-2 удаа | 34.2 | 42.7 | 36.6 | 38.2 | 38.1 |
| 3-4 удаа | 6.1 | 6.8 | 6.7 | 3.7 | 3.3 |
| 5 -аас дээш удаа | 7.2 | 6.9 | 10.0 | 7.6 | 5.5 |

Эмэгтэй сурагчдын хувьд интернэт орчинд танилцсан хүнтэйгээ биечлэн уулзсан хувь эрэгтэй сурагчдаас 8.9 хувиар илүү байна.

### *5.4. Хариу үйлчилгээнд хамрагдах чадамж*

Хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд хүүхдүүд хүчирхийллийг таньж, мэдээлэх мэдлэг, чадвар, хандлагатай байх нь чухал байдаг. Бид судалгаандаа өсвөр насны хүүхдүүдийн хувьд энэ талын мэдлэг, чадвар, хандлагыг "Хэрвээ танай ангийн хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн талаараа хамгийн түрүүнд чамд хэлбэл чи юу хийх вэ?"

гэсэн асуултаар мэдэхийг зорьсон. Хүүхдүүдийн 33.7 хувь нь ээж, аавдаа,

*Хөдөөгийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Цахим хүчирхийлэл байгаа. Бие биеэ дооглох, зургийг нь цахим орчинд тавих гэх мэт асуудлууд байна. Энэ талаар нийгмийн ажилтан зөвлөгөө мэдээллээр сайн хангаж ойлгуулдаг. Гэтэл багш нараас тусдаа групп чатууд бий, тэгэхээр бүрэн хянах ямар ч боломжгүй."*

27.3 хувь нь сургуулийнхаа нийгмийн ажилтанд хандахыг зөвлөнө гэжээ.

*Хөдөөгийн сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*"Ангийн охидтойгоо ярилцахад, нэг охинд хажуу айлын залуу чатаар бэлгийн дарамт үзүүлсэн байсныг мэдэж нийгмийн ажилтантай уулзан, ээжид нь мэдэгдэж, цахим орчинд зөв байх, өөрийгөө хамгаалах талаар мэдээлэл өгсөн."*

*Зураг 5.4. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл авсан тохиолдолд авах арга хэмжээ, хувиар*




Сургуулийн сэтгэл зүйчид 9.5 хувь нь, Хүүхдийн тусламжийн 108 утсанд өсвөр үеийнхний 11.1 хувь нь хандана гэсэн бол цагдаагийн газар хандах хүүхэд 6.5 хувийг эзэлж байна.

Жендэрт суурилсан болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлд анхан шатны нэгж дээр хариу үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй Хамтарсан багт хандах хүүхэд дөнгөж 0.7 хувийг эзэлж байна. Харин "хэнд ч хэлэхгүй нуусан нь дээр" гэж үзэх хүүхэд 2.1 хувь, хаана хэнд хандахыг  мэдэхгүй хүүхэд 6.5 хувийг эзэлж байна.

Эрэгтэй сурагчдын 33.6 хувь сургуулийн нийгмийн ажилтанд хандана гэсэн нь эмэгтэй сурагчдаас (22.7 хувь) 10.0 орчим хувиар илүү байна.

Эмэгтэй сурагчид (40.1 хувь) ээж аавдаа хандах нь эрэгтэй сурагчдаас 13.6 хувиар илүү байна. Мөн эмэгтэй хүүхдүүдийн (4.8 хувь) цагдаад хандахыг илүүд үзэж байгаа бол хүүхдийн тусламжийн 108 утсанд хандах эрэгтэй хүүхдүүдийн хувь эмэгтэй сурагчдаас илүү байна. Сэтгэл зүйчид хандана гэсэн эмэгтэй сурагчдын хувь (11.9 хувь) эрэгтэй сурагчдынхаас (6.8 хувь) ойролцоогоор 2 дахин илүү байна.

Хүүхдэд өөрөө эсвэл хэн нэгэн дотнын хүн нь хүчирхийлэлд өртвөл нэн тэргүүнд эцэг, эхдээ, эсвэл сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, Хүүхдийн тусламжийн 108 утас, цагдаагийн байгууллагад заавал мэдэгдэж тусламж, дэмжлэг авах, аюулгүй байдлаа хамгаалуулах талаар зөвлөмж, мэдээллийг үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай байна.

*Зураг 5.5. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаар мэдээлэл авсан тохиолдолд авах арга хэмжээ, хүйсээр*




Хөдөөгийн хүүхдүүд сургуулийн нийгмийн ажилтанд хандах нь хотын сурагчдаас 10.0 хувиар илүү байна. Харин Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандахыг зөвлөсөн хотын сурагчид (12.4 хувь) хөдөөгийнхнөөс (6.4 хувь) 2 дахин илүү байв. Хотын хүүхдүүд (10.4 хувь) сэтгэл зүйчид хандах талаараа хөдөөгийн сурагчдаас (6.4 хувь) 4.0 хувиар, цагдаад хандах талаараа 2.7 хувиар илүү байна. Хөдөөгийн хүүхэд хэнд хандах талаар мэдэхгүй байх нь хотын хүүхдүүдээс бараг 2 дахин илүү байна.

### *5.5. Уралдаанч хүүхдийн нас*

Үндэсний уламжлалт спорт болох хурдан морины уралдаанд хэдэн настай хүүхэд оролцох талаар олон жил хэлэлцэгдсэн, шийдвэрлэгдээгүй асуудлын нэг юм. Тус судалгаагаар, өсвөр насны хүүхдийн хурдан морийг унаж уралдах насны талаар үзэл бодлыг тодруулав.

*Зураг 5.6. Хурдан морийг унах тохиромжтой хүний талаар үзэл бодол, хувиар*




Хариултаас харахад хүүхдүүдийн 39.2 хувь нь 8-13 настай хүүхэд хурдан морь унаж уралдуулж болно гэж үзсэн. Харин 12.7 хувь нь 8-аас доош настай хүүхэд унаж болно гэсэн хариултыг сонгожээ. Харин 4 хүүхэд тутмын 1 нь хурдны морийг насанд хүрсэн хүнээр унуулсан нь дээр гэж үзэж байна. Хотын хүүхдүүдийн хувьд насанд хүрсэн хүнээр унуулах ёстой гэсэн хариултыг сонгосон хүүхэд ийм хариулт өгсөн хөдөөгийн хүүхдээс ойролцоогоор 3 дахин их байна. Робот буюу хиймэл хүнээр унуулахыг хүүхдүүдийн 7.9 хувь нь сонгожээ.

*Зураг 5.7. Хурдан морийг унах тохиромжтой хүний талаар үзэл бодол, хувиар*



### *5.6. Хүүхдийн хөдөлмөрийн зохицуулалт*

Өсвөр насны хүүхдүүдийг оройн цагаар урлаг, спортын арга хэмжээнд үзүүлбэрт оролцуулахын өмнө эцэг, эх, асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авах ёстой гэх Хөдөлмөрийн хуулийн заалт[28] амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа гэж чи бодож байна вэ?" асуултыг асуухад дараах зураглалд үзүүлсэн хариултыг өгчээ.

*Зураг 5.8. Өсвөр насны хүүхдүүдийг оройн цагаар урлаг, спорт болон бусад арга хэмжээнд оролцуулахын өмнө эцэг, эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авах талаар хуулийн заалтын хэрэгжилтийн байдал, хүйсээр, байршлаар*




Хүүхдүүдийн 60.0 орчим хувь нь хуулийн заалт хэрэгжихгүй байгаа, мэдэхгүй гэсэн хариултуудыг өгчээ. Чанарын судалгаанд оролцсон багш нар сурагчдыг тэмцээн уралдаанд явахад нь эцэг, эх, байрын багшаас нь гарын үсэг зөвшөөрөл авдаг болсон талаар дурдсан.

## ДҮГНЭЛТ

Өсвөр насны хүүхдүүдийн багагүй хувь нь гэр бүлийн гишүүдийн хамт амьдарч чадахгүй байгаа нь хүүхдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх шаардлагатайг харуулж байна.

Дүү нараа харж, гэр бүлийнхнээсээ тусдаа бие даан амьдарч байгаа малчдын хүүхдүүдэд хараа хяналт, дэмжлэг зөвлөгөө хэрэгтэй байна. Мөн огт хараа хяналтгүй ганцаараа амьдарч байгаа хүүхдүүд тодорхой түвшинд байгаа нь, энэ талаар судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үндэсний түвшинд авах шаардлагатайг нотолж байна. Хараа хяналтгүй үлдэж байгаа хүүхдүүдийн хувьд архи, тамхины хэрэглээ, осол гэмтэлд өртөх, хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч болох, охидын жирэмслэлт зэрэгт хүргэх эрсдэлтэй.

Дөрвөн хүүхэд тутмын 1 нь хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд бие махбодын шийтгэл зайлшгүй хэрэгцээтэй гэдэгтээ санал нийлж байгаа нь бие махбодын шийтгэлээс ангид байх эрхийн тухай ойлголтыг суралцагч

28 УИХ. 2001 он. Хөдөлмөрийн тухай хууль. 142-р зүйлийн 5-р заалт

бүрд сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулж хүргэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэлээ. Интернэт орчинд огт уулзаж байгаагүй хүнтэйгээ харилцах, интернэт орчинд танилцсан хүнтэйгээ биечлэн уулзах зэргээр хүүхдүүд цахим дээрэлхэлт болон цахим орчинд бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй тулгарч байна. Монгол Улсын Их Хурлаас 2022 онд баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулиар хурдан морийг 8 ба түүнээс дээш насны хүүхэд унаж уралдуулахаар зохицуулсан.

Хурдан морийг 8-аас доош настай хүүхэд унахыг хүүхдүүдийн 87.0 хувь нь дэмжихгүй байна.

"Өсвөр насны хүүхдүүдийг оройн цагаар урлаг, спорт, загварын тоглолт, үзүүлбэрт оролцуулахын өмнө эцэг, эх, асран хамгаалагчаас нь зөвшөөрөл авах ёстой" гэдэг хууль тогтоомжийг хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчид, олон нийтэд сурталчлах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Хүчирхийллийн асуудлаар нийгмийн ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчдаа хүүхдүүд хандаж шаардлагатай хариу үйлчилгээг авч сурах хэрэгтэй байна. Хүүхэд хамгааллын дуудлагыг шуурхай хүлээн авч яаралтай хариу үйлчилгээнд холбон зуучлах үүрэгтэй Хүүхдийн тусламжийн 108 утсанд өсвөр насны хүүхдийн хандалтыг нэмэгдүүлэх шаардлагатай болжээ. Жендерт суурилсан болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлд анхан шатны нэгж дээр хариу үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй хамтарсан баг өсвөр насны хүүхдүүдтэй тулж ажиллаж тэдэнд танигдах шаардлагатай байна. Хэнд ч хэлэхгүй нуух нь хүчирхийллийг даамжруулж улам их хор нөлөөг өөрт нь болон үе тэнгийнхэнд авчирна гэдгийг өсвөр насныханд ойлгуулах мэдээлэл сурталчилгааны ажлын хэрэгцээ нэмэгдэж байна. Мөн мэдээллийн нууцлал хадгалагдана гэсэн итгэл найдварыг хүүхэд, гэр бүлд төрүүлэхүйц арга барил, салбар хоорондын мэдээллийн менежментийг нэвтрүүлэх хэрэгтэй байна.Эрэгтэй сурагчдын эцэг, эхдээ хандахаас илүү сургуулийн нийгмийн ажилтан болон Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандахыг илүүд үзсэн байгаа нь эцэг, эх нь хөвгүүдийнхээ итгэлт хүн нь байхын тулд хүмүүжлийн арга барилдаа дүгнэлт хийх хэрэгтэйг харуулж байна. Эмэгтэй сурагчдын хувьд сэтгэл зүйчээс үйлчилгээ авах сонирхол илүү байна. Хөдөөгийн сургуулийн нийгмийн ажилтнууд хүүхдүүддээ илүү танигдаж чадсан нь сайшаалтай. Гэхдээ хөдөөгийн сургуулиуд сэтгэл зүйчтэй болох, хамтарсан багийн гишүүд, ажилтнууд хүүхдүүдэд ажил үйлчилгээгээ сурталчлан ойлгуулах ажлыг түлхүү хийх хэрэгтэй болжээ.

# 6. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРХ

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн өнөөгийн байдал

Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр насны хүүхэд тэгш хамруулан сургах хөтөлбөрт хамрагдаж, ердийн сургуульд суралцах орчин тэдэнд ээлтэй байж чадаж байгаа эсэх, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хөтөлбөрт хамрагдах боломжийн бүрдсэн байдал, бусад үе тэнгийнхэн нь хэрхэн хандаж байгааг мэдэх зорилготой цөөн асуултыг судалгаанд ашигласан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд сургуульд хүрж очих зам, хаалга, шат, бие засах газар, анги танхим цогцоороо хүртээмжтэй, аюулгүй байгаа нөхцөлд хүүхдүүд сурах эрхээ бүрэн эдэлж чадна. Мөн тэдэнд хөгжлийн бэрхшээлийнх нь онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр, тусгай хэрэгцээнд нь нийцсэн сургах арга барил эзэмшсэн багш, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох боломжийг нь дэмжсэн орчин хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэгш хамруулах сургалтын үр нөлөөг хүртэхэд ялгаварлан гадуурхалт, бүх төрлийн хүчирхийллээс ангид орчин чухал үүрэгтэй. Хамт суралцагч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдүүдийн зүгээс ялгаварлан гадуурхах, үл хайхрах, дээрэлхэх, сэтгэл санааны хүчирхийлэлд өртүүлэх эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй байх, сурах үйл ажиллагаанд нь саад учруулахгүй байх нь чухал ач холбогдолтой.

### *6.1. Сургуулийн орчны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал*

Ерөнхий боловсролын сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлж чадаж буй эсэхийг өсвөр насны хүүхдүүд хэрхэн дүгнэж буйг мэдэх зорилгоор нийт 3 асуултыг судалгааны асуулгад  оруулсан. Багш нараас тухайн сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй эсэх талаар асуусан. Мөн сургууль дээр очиж ажилласан судалгааны багийнхан ажиглалтын хуудсаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдлыг дүгнэснийг тайланд ашиглав. Хүүхдийн 21.6 хувь нь сургуулийнхаа орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжтой гэж дүгнэсэн байна.

*Зураг 6.1. Сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал*




Хотын сургуулиудын 60.0 орчим хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө хоёроос хэтрэхгүй тоотой байв. Гэвч ариун цэврийн өрөө, налуу зам давхар бүрд байхгүйгээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зөвхөн доод давхарт л бие засах өрөө ашиглаж, зорчих боломжтой байлаа. Ариун цэврийн өрөө тусгайлан тохижуулсан ч ганцаараа бие засах боломжгүй учраас асран хамгаалагч нь тодорхой цагийн завсарлагаанаас ирж бие засуулдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бага ангид суралцаж төгсгөөд дунд ангид ороод сургуулиас гарсан кейсийг багш нар дурдаж байв. Мөн эцэг, эхийн дэмжлэгтэйгээр байгуулсан бие засах өрөө нь зөвхөн эмэгтэй хүүхдийн бие засах хэсэгт байгуулагдсан учраас хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй хүүхэд ашиглах боломжгүй байгаа кейс яригдсан. Хөдөөгийн сургуулийн хувьд хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ашиглах ариун цэврийн өрөөтэй сургууль байсангүй. Харин нэг сумын сургуулийн дотуур байранд төслийн шугамаар суултуур байрлуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах гэсэн зориулалттай хийсэн ч бохир усны хоолой эвдэрсэн шалтгаанаар бүхэлдээ ажиллахгүй байгааг сургуулийн удирдлага танилцуулсан.

Сургуульд орох гарах налуу зам байлаа ч тухайн хаалганаас цаашлаад зориулалтын тэмдэг тэмдэглэгээ байхгүй, шороон замтай тул тэргэнцэртэй хүүхэд ганцаараа явах боломжгүй, налуу шаттай хэдий ч стандарт бус хэт огцом эсвэл шатны бариулгүй сургууль олон байна. Хүүхдийн ачаалал хэтэрсэн сургуулиудад хонгилоор таягтай юм уу тэргэнцэртэй хүүхэд явахад хэтэрхий давчуу байгаа нь хүүхэд бэртэж гэмтэхэд хүргэж болзошгүй эрсдэлээс болгоомжлох хэрэгтэй болгож байна.Дотуур байрны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амьдарч суралцах, тоглох боломжийг бүрэн хангасан дотуур байр байхгүй байгаа нь судлаачдын ажиглалтын тэмдэглэлээс харагдлаа. Хуучин хичээлийн болон дотуур байртай ихэнх сургуулийн хувьд анх баригдахад төлөвлөөгүй учир нэмэлт төлөвлөлт хийхэд зай талбай, төсөв хүрэлцээгүй гэсэн нийтлэг шалтгааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан бие засах өрөө байхгүй, налуу шатгүй гэж багш нар тайлбарлажээ. Гэсэн хэдий ч орон нутагт шинээр

сургууль төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд зориулж налуу замаар дээд давхар, спортын танхим, хөгжлийн өрөө, бие засах газарт очих боломжтой зураг төслөөр барьсан сургууль Архангай аймгийн Эрдэнэмандал суманд байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургуулийн барилгын зураг төсөл манай улсад нэвтэрснийг харуулж байв.Багш нарын хувьд тэгш хамруулан сургах бодлого зарчмын талаар түр хугацааны тусгай сургалтад хамрагдсан ч яг ямар бэрхшээлтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах талаар нарийвчилсан арга зүйн дэмжлэг сургалт хэрэгтэй байгаа тухай дурдаж байв. Ялангуяа, унаж татдаг өвчтэй, гэнэт тусламж шаардлагатай болдог хүүхдэд анхны тусламж үзүүлэх талаар мэдээлэл сургалт шаардлагатай байгааг багш нар хэлж байв. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ганцаарчлан ажиллах төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрхэн боловсруулах арга зүйд нийт багш нарыг сургах хэрэгцээтэй байна. Мөн ганцаарчлан ажиллах анги танхим, цагийн зохицуулалтад анхаарах хэрэгтэйг тэд дурдаж байв.

### *6.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөгжлийн үйлчилгээний хүртээмж*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд бусад хүүхдийн нэгэн адилаар хичээлээс гадуурх үйл ажиллагаа, сургалт, оролцооны хөтөлбөрт хамрагдаж өөрсдийгөө хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох чадвараа дээшлүүлэх, чөлөөт цагаараа тоглож наадах эрхтэй. Гэвч өсвөр насны хүүхдүүдийн 88.0 хувь нь сургууль дээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулдаг дугуйлан, секц, оролцооны клуб, сурагчдын зөвлөл байхгүй, энэ талаар мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Судалгааны явцад хийсэн ажиглалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тоглоом, тоног төхөөрөмжийг сургуулийн спорт тоглоомын талбайд байрлуулсан сургууль байгаагүйг судлаачид тэмдэглэжээ.

*Зураг 6.2. Сургууль дээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оролцуулдаг дугуйлан, секц, оролцооны клуб, зөвлөл байгаа эсэх талаар хүүхдийн мэдлэг, хүйсээр, байршлаар*

А. Хүйсээр Б. Байршлаар



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагын талаарх хүүхдүүдийн ойлголт хангалтгүй байгаа нь “Танай сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжтой эсэх” гэдэг асуултад 4 хүүхэд тутмын 1 нь “мэдэхгүй байна” гэсэн хариулт сонгосноос харагдаж байна. Хөдөөгийн хүүхдүүдийн хувьд 27.1 хувь нь энэ талаар мэдлэг ойлголтгүй байгаагаа хэлжээ. Үүнийг “энгийн хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй хамт суралцах ойлголт, мэдээлэл багатай байгаа нь сургалтад бэрхшээл учруулж байна“ гэсэн багш нарын яриа нотолж байв. Мөн багш нарын дунд ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах, хөгжих орчин хүртээмжгүй гэж дүгнэсэн.

*Хотын сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тулж ажиллахад хэцүү, маш их хугацаа шаарддаг тул бусад олон хүүхдээ анхаарахгүй өнгөрөөх магадлал ихтэй.”*

*Хотын сургуулийн багш нартай хийсэн ярилцлагаас:*
*“Манай сургуульд нийт 13 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг бөгөөд тэдгээрийн оролцооны түвшнийг үнэлбэл 20 хувьтай гэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өөрсдөө аль болох хойш суугаад үлдэх хүсэлтэй байдаг.”*

## *6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хандах үе тэнгийнхний үзэл бодол*

*Зураг 6.3. Сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байдал, байршлаар*




Хэдийгээр хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй ердийн сургуульд суралцахад дэмжлэг болох онцлог хэрэгцээ шаардлагыг сайн мэдэхгүй байгаа ч тэднийг дэмжих хандлага ихэнхэд нь байгаа нь сайн хэрэг юм. Тухайлбал, хүүхдүүдийн 66.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өөрийнхөө чадахаар туслахыг бодно гэсэн байна. Энэ хариултыг сонгосон эмэгтэй сурагчдын хувь 2.9 хувиар илүү байна.

Хүйсийн хувьд харилцааны чадварын ялгаа байж магадгүй нь “надаас өөрөө тусламж хүсвэл л тусална” гэсэн эрэгтэй сурагчдын хувь ийм хариулт сонгосон эмэгтэй сурагчдаас 4.0 хувиар илүү байна. Харин “чамд ямар тусламж хэрэгтэй вэ?” гэж асууна гэсэн эмэгтэй сурагчдын хувь нь 2.6 хувиар илүү байгаагаас харагдаж байна.

*Зураг 6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд шилжин ирсэн тохиолдолд хандах хандлага, хүйсээр*




## ДҮГНЭЛТ

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах зарчим боловсролын хууль тогтоомжоор баталгаажсан ч бодит амьдрал дээр сайжруулах зүйл нэлээд байна. Хуучин барилга байгууламжтай, зай талбай хүрэлцээгүй, төсөв хөрөнгө хангалттай биш гэсэн шалтгаанаар олон сургуулийн орчин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй байж чадахгүй байна. Налуу зам барих, бие засах өрөөг тусгайлан тоноглох зэрэг ажлууд зарим сургууль дээр хийгдсэн ч гэрээс сургууль орох зам, сургуулийн давхар хооронд зорчих шат, нэгээс дээш давхарт байрлах бие засах газар шинэчлэгдээгүйгээс болоод хийсэн ажлынх нь үр дүнг хүүхдүүд бүрэн хүртэж чаддаггүй байна. Зарим газар шинээр хийгдсэн налуу зам, бие засах газар нь стандартын шаардлагын дагуу хийгдээгүйгээс хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхэд ашиглах боломжгүй байв. Дотуур байрны хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд амьдрах, тоглох, суралцах боломжийг цогц хангасан газар байхгүй байна.Хотын сургуулиудын хэтэрсэн ачаалал нь

хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургууль дотроо чөлөөтэй зорчих боломжийг хязгаарлаж байна.Багш нарын хувьд тэгш хамруулан сургах бодлого зарчмын талаар сургалтад хамрагддаг ч тэдэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй тулж ажиллах, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх, ганцаарчлан сургах төлөвлөгөө боловсруулах зэрэгт арга зүйн дэмжлэг хэрэгтэй байна. Бас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тулж ажиллах анги танхим, хичээлийн цагийн зохицуулалтыг хүртээмжтэй болгох шаардлагатай байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хичээлээс гадуурх клуб, дугуйлан, хүүхдийн оролцооны байгууллагад харьяалагдаж ердийн хүүхдийн адил хөгжил, оролцооны эрхээ эдэлж чадахгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, тэдний онцлог, тэгш хамруулах сургах зарчмын талаар мэдлэг мэдээлэл өсвөр насны хүүхдэд хангалттай биш байна. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй үе тэнгийнхнийхээ хэрэгцээ шаардлагыг сайн мэдэхгүй байгаа ч хүүхдүүдийн дийлэнх нь өөрийнхөө чадах хэмжээнд тэдэнд туслахад бэлэн байгаа нь сайшаалтай.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ


1. https://www.1212.mn/mn Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
2. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. 2022 оны жилийн эцсийн мэдээ
3. Цагдаагийн ерөнхий газрын 108-утас дуудлагын мэдээлэл
4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны жилийн эцсийн мэдээ
5. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. 2022 онд үндэсний хэмжээнд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоон мэдээ
6. https://information.police.gov.mn/ Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын статистик тоон мэдээлэл. Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг
7. https://www.tandfonline.com/doi/full/10.1080/09243453.2019.1623450 Trude Nilsen, Ronny Scherer. (2019) Closing the gaps? Differential effectiveness and accountability as a road to school improvement. School effectiveness and school improvement. An international Journal of Research, Policy and Practice. Volume 30.
8. Засгийн газрын хэрэг эрхлэх газар. 2023. Сурч боловсрох эрх: дотуур байр үндэсний II зөвлөгөөн"-ий тайлан
9. https://news.mn/r/2670082/
10. Хүүхдийн оролцооны үндэсний чуулган.20236 https://news.mn/r/2668522/
11. http://time.mn/rAv.html
12. https://ikon.mn/n/2w5h БШУЯ-ны Сайд. Л.Энх-Амгалангийн 2023 оны 6 сарын 20-д өгсөн ярилцлага.
13. Raquel. B etc (2023) School Greenness and Student-level Academic Performance: Evidence from the Global South. Journal Advanced Earth and Space Sciences. Https://agupubs.onlinelibrary.wiley.com/doi/10.1029/2023gh000830
14. https://www.mnb.mn/i/104626
15. Сурч боловсрох эрх: Дотуур байр үндэсний II зөвлөгөөн. БШУЯ. 2023 он
16. Хүүхдийн эрхийн тухай хууль
17. ГБХЗХГ 2022 оны Тайлан
18. MNS 6782:2019. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
19. MNS 6781:2019. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага
20. https://legalinfo.mn/ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Боловсролын ерөнхий хууль. 10.1.7

21. Special Representative of the Secretary-General on Violence against Children (2012). Tackling violence in schools: A global perspective bridging the gap between standards and practice.
22. https://www.meds.gov.mn/post/105096
23. НҮБ-ын Хүүхдийн Сан. Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам. УБ. 2021. 26 х.
24. УИХ. 2001 он. Хөдөлмөрийн тухай хууль. 142 дугаар зүйлийн 5-р заалт

## СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Эрүүл мэндийн яам
Боловсрол, шинжлэх ухааны яам
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
Нийслэлийн Боловсролын газар
Аймаг, дүүргийн Боловсролын газар
Сонгогдсон Ерөнхий боловсролын сургуулиуд

## ЗӨВЛӨХИЙН БАГ:

| | |
|---|---|
| А.Амарбал | Ахлах зөвлөх<br>Нийслэлийн бодлогын судалгаа, шинжилгээний төвийн Нийгэм, эдийн засгийн судалгааны газрын захирал |
| С.Энхтуяа | Арга зүйн зөвлөх |

## Судалгааны тайлан хянасан:

| | |
|---|---|
| Н. Баярмаа | ХНХЯ-ны ГББХЗГ-ын дарга |
| С. Өнөрсайхан | НЭМҮТ-ийн захирал |
| Б. Батбаатар | ХНХСҮСИ-ийн захирал |
| Д. Амараа | НҮБХС-гийн Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн |
| С. Болормаа | ДЭМБ-ын мэргэжилтэн |
| С. Санжаабадам | БСҮХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга |
| Ж. Азжаргал | ХНХЯ-ны ГББХЗГ-ын мэргэжилтэн |
| Б. Дуламсүрэн | БШУЯ-ны ЕББУЗГ-ын шинжээч |
| Б. Дөлгөөн | ЭМЯ-ны НЭМГ-ын мэргэжилтэн |
| Г.Ариунчимэг | ГБХЗХГ-ын ССМТ-ийн захирал |

## Судалгааны удирдагч:

| | |
|---|---|
| С. Өнөрсайхан | НЭМҮТ-ийн Захирал |
| Б. Батбаатар | ХНХСҮСИ-ийн Захирал |

## Судалгааны зохицуулагч:

| | |
|---|---|
| Ц. Уянга | ХНХСҮСИ-ийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан |
| М. Цолмон | НЭМҮТ-ийн мэргэжилтэн |

## Судалгааны тайлан бичсэн:

| | |
|---|---|
| Ц. Уянга | ХНХСҮСИ-ийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан |
| М. Нарантуул | НБСШТ-ийн шинжээч |
| Д. Нүрмаа | НБСШТ-ийн шинжээч |
| М.Энхбаяр | БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан |
| Ү. Энхцэцэг | Мэдээлэл боловсруулалтын программист |
| Б. Алтангэрэл | Судлаач, бүлгийн ярилцлага боловсруулсан |
| М. Цолмон | НЭМҮТ-ийн мэргэжилтэн |
| Ц.Отгонхорлоо | ГБХЗХГ-ын ССМТ-ийн ажилтан |

# ХАВСРАЛТ

## ХАВСРАЛТ 1. ТАНИЛЦУУЛГА, ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

### СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЭЦЭГ, ЭХ АСРАН ХАМГААЛАГЧДАД ӨГӨХ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) хамтран зохион байгуулж байгаа “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа”-нд оролцохыг урьж байна. Ингэснээр та цаашдын хүүхдийн эрх хамгааллын бодлого, хөтөлбөрт хувь нэмрээ оруулах болно

**1 Бид яагаад энэ судалгааг хийж байгаа вэ?**

Бид энэхүү судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулснаар олон улсын болон Монгол улсын хувьд боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын талаархи нэн хэрэгцээтэй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох, өнөөгийн нөхөл байдлыг тодорхойлох, чиглэлээр цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг бий болгох зорилготой.

**2 Судалгаанд ямар мэдээллүүдийг цуглуулах вэ?**

Энэхүү судалгаанд хүнс, хоолны хэрэглээ, эрүүл ахуйн дадал, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, тамхи, архины хэрэглээ, хамгаалах хүчин зүйлс, бэлгийн зан үйл гэсэн 8 үндсэн модулиас бүрдсэн 74 асуумж бүхий мэдээллийг таны хүүхдээс асуухаас гадна хүн ам зүйн мэдээлэл, хүүхдийн оролцоо, хүүхдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ гэсэн үзүүлэлт бүхий 36 асуумжаар мэдээллийг цуглуулна. Мэдээллийг ДЭМБ-ын аргачлалын дагуу тусгай хариултын цаасан дээр сурагчдаар өөрсдөөр нь харандаагаар бөглүүлэх юм.

**3 Энэ судалгаанд та заавал оролцох ёстой юу?**

Судалгаанд оролцох эсэхээ та өөрөө шийднэ.

Хэрэв та хүсэхгүй байгаа бол хүүхдээ оролцуулахгүй байж болно. Хэрэв та судалгааны үеэр бодлоо өөрчилбөл судлаачдад мэдэгдээрэй.

Таны хүүхэд судалгаанд оролцсон эсэхээс таны хүүхдийн сурлагын явц, хүүхдийн сургууль дээрх тогтмол үйл ажиллагаа өөрчлөгдөхгүй.

**4 Энэ судалгаанд оролцохын давуу тал юу вэ?**

“СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ” нь манай судалгаанд хамрагдаж, бидэнд шаардлагатай мэдээллийг өгснөөр өөрийнхөө болон үе тэнгийнхэнд нь үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ, шаардлага хангагдаж, хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулах болно.

**5 Оролцохын сул тал нь юу байж болох вэ?**

Дараах сул талууд байж болно:

- Зарим асуултын сэдэв (бэлгийн зан үйл, хүчирхийлэл, дээрэлхэлт) хүүхдэд таагүй мэдрэмж төрүүлж магадгүй.
- Энэ судалгаанд оролцоход тодорхой цагийг (40 минут хүртэл) зарцуулна.

**6 Судалгаанд оролцоход надад мөнгө төлөх үү?**

Энэхүү судалгаанд оролцож цаг заваа гаргасанд талархаж, судалгаанд оролцогч бүрт ........... төгрөгний утасны нэгж өгөх болно.

**7 Судалгаанд оролцогчийн мэдээллийг хэрхэн хамгаалах вэ?**

Судалгааны явцад оролцогчтой холбоотой нууцлалыг зохих журмын дагуу чандлан хадгалах ба хариултын хуудас дээр сурагч нэрээ бичихгүй. Мөн судалгааны үр дүнгийн тайланд таны хүүхдийн сургууль, анги, хувь хүний нэр, түүнтэй холбоотой мэдээллүүдийг оруулахгүй.

**8 Нэмэлт мэдээлэл**

Энэхүү судалгааны талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл судалгааны багийн гишүүдтэй холбогдоно уу:
*А. Амарбал – Судалгааны зөвлөх (утас-99091338)*
С.Энхтуяа- *Судалгааны зөвлөх (утас-99004924)*

## СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЭЦЭГ, ЭХ АСРАН ХАМГААЛАГЧДАД ӨГӨХ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Намайг ............................... гэдэг. Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) хамтран зохион байгуулж байгаа “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа”-ны гэрээт судлаачаар ажиллаж байна. Бид энэхүү судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулснаар олон улсын болон Монгол улсын хувьд боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгааллын талаахи нэн хэрэгцээтэй шалгуур үзүүлэлтүүдийг тооцох, өнөөгийн нөхөл байдлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг бий болгох болгох зорилготой.

Энэхүү судалгаанд хүнс, хоолны хэрэглээ, эрүүл ахуйн дадал, осол гэмтэл, хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, тамхи, архины хэрэглээ, хамгаалах хүчин зүйлс, бэлгийн зан үйл гэсэн 8 үндсэн модулиас бүрдсэн 74 асуумж бүхий мэдээллийг таны хүүхдээс асуухаас гадна хүн ам зүйн мэдээлэл, хүүхдийн оролцоо, хүүхдэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ гэсэн үзүүлэлт бүхий 36 асуумжаар мэдээллийг цуглуулна. Мэдээллийг ДЭМБ-ын аргачлалын дагуу тусгай хариултын цаасан дээр сурагчдаар өөрсдөөр нь харандаагаар бөглүүлэх юм.

“СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ” нь манай судалгаанд хамрагдаж, бидэнд шаардлагатай мэдээллийг өгснөөр өөрийнхөө болон үе тэнгийнхэнд нь үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ, шаардлага хангагдаж, хүүхэд хамгааллын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулах болно.

**Судалгааны сонголт:** Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон Монгол улсын хот, суурин газар, хөдөө орон нутгийн нийт 51 сургуулийн 13-17 насны 3556 сурагч хамрагдана. Сурагч асуумжийг бөглөхөд дунджаар 40-50 мину зарцуулна.

**Эрсдэл:** Судалгааны асуумжийг хангасан орчин, нөхцөлд хийх ба хүүхдийн жин өндрийг хэмжихдээ хувь хүний нууц, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтална. Та болон таны хүүхэд судалгаанд оролцохоос татгалзаж болох бөгөөд таныг судалгаанд оролцохоос татгалзсаны төлөө сургууль болон бусад байгууллагаас танд ямар нэг дарамт, шахалт үзүүлэх, үйлчлэхээс татгалзах зэрэг үйл ажиллагаа явагдахгүй болно.

**Нууцлал:** Судалгааны явцад оролцогчтой холбоотой нууцлалыг зохих журмын дагуу чандлан хадгалах ба хариултын хуудас дээр сурагч нэрээ бичихгүй. Мөн судалгааны үр дүнгийн тайланд таны хүүхдийн сургууль, анги, хувь хүний нэр, түүнтэй холбоотой мэдээллүүдийг оруулахгүй.

**Төлбөр:** Энэ судалгаанд хамрагдсанаар та ямар нэгэн төлбөр төлөхгүй. Бид судалгаанд оролцсон хүүхэд бүрд цаг заваа гаргасныг урамшуулж утасны нэгж өгөх болно.

**Асран хамгаалагч:** Би энэхүү зөвшөөрлийн хуудастай бүрэн танилцаж, уг судалгаанд хүүхдээ оролцохыг зөвшөөрч байна. Миний бие энэхүү судалгаанд гарын үсгээ зурснаар хүүхдээ судалгаанд оролцохыг зөвшөөрч байгааг илэрхийлнэ.

Судалгаанд оролцогч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн
Овог .............................Нэр ..............................
Гарын үсэг ........................................
Утасны дугаар......................................

**Зөвшөөрсөн 2023 оны ........ сарын .......... өдөр**

Судалгаатай холбоотой асуудлаар судалгааны ажлын удирдагч, С.Өнөрсайхан (*Утас: 99113658, Имэйл хаяг: unursaikhan.suren@gmail.com), Судлагааны Зөвлөх А. Амарбал (Утас 99091338, Имэйл хаяг: amarbalmgl@gmail.com) Судлагааны зөвлөх С. Энхтуяа (Утас 99004924, Имэйл хаяг: tuyasukhmn@gmail.com)* зохицуулагч *Д.Дэлгэрмаа (Утас: 91990980, Имэйл хаяг: ddelgermaa0920@gmail.com)* нартай холбоо барина уу.

## Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа

## Багш, нийгмийн ажилчдад зориулсан мэдээлэл

| | |
|---|---|
| **Танилцуулга** | ................ сургууль нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ) хамтран Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) аргачлалаар явуулж байгаа *“Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн судалгаа”-нд* оролцож байгаа юм. Энэхүү судалгааны нэгэн хэсэг нь цөөн тооны багш, нийгмийн ажилчдаас ярилцлага авч судалгааны нэгдсэн мэдээлэлд ашиглах юм. Энэ судлагааны үр дүн нь ирээдүйд сурагчид, өсвөр насныханд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулахад ашиглагдана. |
| **Судалгааны аргачлал** | Судалгааны нэгэн хэсэг болох бүлгийн ярилцлагыг 6-8 хүнтэй явуулах ба энэхүү ярилцлагад сургууль болон сургуулийн ойролцоох орчин, нөхцөл, хүүхдийн эрхийн хамгааллын талаар асуух юм. Судалгаанд оролцсоноор танд учрах сөрөг нөлөө байхгүй. |
| **Үргэлжлэх хугацаа** | Бүлгийн ярилцлага дунджаар 120 мин үргэлжилнэ. |
| **Хувийн мэдээлэл** | Судлагааны арга зүй нь оролцогчдын хувийн нууцыг хамгаалахыг бүх талаар анхаарсан. Судалгааны мэдээллээс таны овог, нэр болон сургуулийн мэдээллийг хасна. Судлагааны үр дүнгийн тайланд сургууль болон таны хувийн мэдээллийн талаар огт дурдахгүй. |
| **Сайн дурын оролцоо** | Хэдийгээр манай судлагаа сайн дурын үндсэн дээр хийгдэх боловч сонгогдсон багш, ажилчид бүрэн хамрагдаасай гэж бид хүсэж байгаа. Ярилцлагын явцад хариулахыг хүсэхгүй байгаа асуултанд хариулахгүй байж болно. Түүнээс гадна ярилцлагын явцад хүсвэл судалгааг орхиж болно. |
| **Дэлгэрэнгүй мэдээлэл** | Хэрвээ танд асуух зүйл байвал дараах хүмүүстэй холбогдоно уу.<br><br>Судалгааны Зөвлөх А. Амарбал: Утас 99091338<br>Судалгааны Зөвлөх С. Энхтуяа: Утас 99004924 |

# СУДАЛГААНД АШИГЛАСАН ЗАРИМ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

| | |
|---|---|
| Өсвөр насны хүүхэд | 10-19 насны хүүхэд[29] |
| Хүүхдийн эрх | ХЭК-оор баталгаажсан, 18 нас хүрээгүй учраас онцгой хамгаалал, халамж анхаарал шаарддаг хүний эрхүүд юм. |
| Хүүхэд хамгаалал | Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, суралцах чадварт сөргөөр нөлөөлж, хүнтэй харьцах зэрэг харилцааг үгүй хийж, өөрийгөө дорд үзэх, сэтгэл санааны зовуурь гутралд хүргэхийн зэрэгцээ амиа егүүтгэх ч эрсдэлийг бий болгодог. эрсдэлт үйлдэл.[30] |
| Хүүхдийн оролцоо | Хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах, аливаа өөрчлөлт хийхдээ хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх, тэдний үзэл бодлыг гаргаж буй шийдвэртээ тусгах, хүүхдүүд эвлэлдэн нэгдэж, нийгмийн амьдралд оролцох гэх мэт өргөн ойлголт. |
| Оролцох эрх | Нийгмийн амьдралд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, өөрт хамааралтай шийдвэрт оролцох эрх. |
| Хүүхдийн хөгжил | Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцааны хувьд ахиц өөрчлөлт. |
| Хүүхдийн хөгжих эрх | Бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцааны хувьд ахиц өөрчлөлт авчрах үйлчилгээ, дэмжлэг, сургалт, зааварчилгаа авах эрх. |
| Хүүхэд хамгаалал | Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалж, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаа.[31] |
| Хүүхдийн хамгаалуулах эрх | Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрх. |
| Боловсролын орчны аюулгүй байдал | Сургуулийн орчин буюу сургуульд эзэмшүүлсэн газар, түүний эргэн тойрны 150 метр газар дах болон хүүхдийн сургуульдаа ирж очих замын аюулгүй байдал.[32] |
| Эрсдэл | Хүүхдийн эрхийг зөрчих, заналхийлэх, улмаар хүүхдэд гэм хор учруулах магадлалыг хэлнэ. Хүүхдийн эрсдэлийг тодорхойлохдоо зөрчил, аюулын төрөл, түүнчлэн хүүхдийн эмзэг байдал, даван туулах дасан зохицох чадварыг харгалзан үздэг. |
| Суралцагч | Боловсролын сургалтын байгууллагад албан ёсоор суралцаж байгаа хүн.[33] |

29 ДЭМБ-ын тодорхойлолт. Дараах цахим хуудсаас 2023 оны 9 сарын 24-нд татав. https://www.who.int/health-topics/adolescent-health#tab=tab_1

30 Хүүхэд хамгааллын тухай хууль.

31 Хүүхэд хамгааллын тухай хууль.

32 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS 6782:2019 стандарт

33 Боловсролын ерөнхий хууль.

# ХАВСРАЛТ 2. АСУУЛТЫН ХУУДАС

## *СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ СУРАЛЦАГЧДЫН ЭРХ, ХАМГААЛЛЫН СУДАЛГААНЫ АСУУЛГА*

Судалгааны энэ хэсэгт бид сургуулийн орчинд хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахын тулд юу хийх хэрэгтэйг мэдэх зорилготой.

Асуултуудад өөрийн бодож байгаагаар л хариулахыг хичээгээрэй. Зөв буруу хариулт гэж байхгүй. Энэ бол шалгалт сорил биш. Асуултад хариулахыг хүсэхгүй бол алгасаж болно.

Асуухаар зүйл гарвал асуулга өгсөн хүнийг сэмхэн дуудаад асууж болно. Чи өөрийн хариултыг чангаар хэлэхгүй л бол хэн ч чиний өгсөн хариултыг мэдэж чадахгүй, нууц хэвээрээ л үлдэнэ.

### Асуумжийг нөхөх заавар

Судалгааны асуултуудыг уншаад тохирох хариултыг сонгож өмнөх үсгийг нь дугуйлна уу. Бусад гэсэн хувилбартай хариултыг сонговол өөрийн хариултыг бичээрэй.

### Хүн ам зүйн мэдээлэл

1. Чи хэдэн настай вэ?
   A. 12 ба түүнээс бага
   B. 13 настай
   C. 14 настай
   D. 15 настай
   E. 16 настай
   F. 17 настай
   G. 18 ба түүнээс дээш
2. Чиний хүйс
   A. Эрэгтэй
   B. Эмэгтэй
3. Чи хэддүгээр ангид суралцдаг вэ?
   A. 8
   B. 9
   C. 10
   D. 11
   E. 12
4. Сүүлийн 7 хоногт хаана амьдарч байгаа вэ?
   A. Гэртээ
   B. Сургуулийн дотуур байранд

C. Асрамжийн газарт
D. Хамаатныдаа
E. Өвөө эмээгийндээ
F. Таньдаг айлынд
G. Намайг сургуульд суулгахын тулд бэлтгэж өгсөн тусдаа гэр, түрээсийн гэр, байшин, орон сууцанд
H. Бусад /бичнэ үү//.......................................................................

5. Сүүлийн 7 хоногт хэнтэй амьдарч байна вэ? Чиний нөхцөлд тохирсон хувилбаруудыг сонгож болно. Жишээ нь Ээж, эмээ өвөөтэйгөө амьдарч байгаа бол B, C, D гэсэн 3 хариултыг сонгож болно гэсэн үг.
   A. Аав
   B. Ээж
   C. Өвөө
   D. Эмээ
   E. Ах, ах нар
   F. Эгч, эгч нар
   G. Хамаатны гэр бүлийнхэн
   H. Таньдаг айлынхан
   I. Дүү, дүү нар
   J. Бусад хүүхдүүдтэй.
   K. Ганцаараа

Дараагийн асуултууд сургуулийн орчны аюулгүй байдал, хүүхэд хамгаалалтай холбоотой.

**Сургуулийн орчин гэдэгт хичээлийн байр, спорт, урлагийн танхим, цайны газар, ариун цэврийн өрөө, жорлон, дотуур байр, сургуулийн гадаах талбай зэрэг орно.**

**Аюулгүй байдал гэж чиний байгаа орчинд хүчирхийлэл, дээрэлхэлт зэрэг чиний сэтгэлийг зовоосон асуудалгүй байхыг хэлнэ.**

6. Өнгөрсөн 12 сарын хугацаанд сургуулийн чинь орчинд яг хаана чиний аюултгүй байдал алдагдсан бэ?
   A. Тийм зүйл огт тохиолдоогүй.
   B. Сургуулийн коридорт
   C. Ангид буюу хичээлийн танхимд
   D. Дотуур байранд
   E. Ариун цэврийн өрөө, жорлонд
   F. Цайны газарт
   G. Биеийн тамирын заал, урлагийн заал зэрэг олон хүүхэд цуглардаг газар

H. Бусад /бичнэ үү/...........................................................................

7. Чи сургуульдаа сүүлийн 30 хоногт ихэвчлэн яаж ирж очдог байсан вэ?
   A. Сургуулийн автобусаар
   B. Нийтийн тээврээр
   C. Хувийн унаагаар
   D. Таксигаар
   E. Явганаар
   F. Дугуйгаар
   G. Мориор
   H. Бусад /бичнэ үү/...........................................................................
8. Сургуульдаа ирж очих замд чинь тааралддаг нийтлэг бэрхшээл юу вэ?
   A. Ямар ч бэрхшээл саад байхгүй.
   B. Гэрэлтүүлэг муу, байхгүй
   C. Автозамын түгжрэл
   D. Гэрлэн дохио ажилладаггүй
   E. Автобусны буудлаас хэтэрхий хол байдаг.
   F. Явган хүний зам байхгүй учраас авто машины хөдөлгөөнөөс айдаг.
   G. Нохойноос айдаг.
   H. Шороон зам өвөл халтиргаатай байдаг
   I. Архи уудаг хүмүүс цуглардаг газраас айдаг.
   J. Бусад бэрхшээл /бичнэ үү/..................................................
9. Сүүлийн 12 сарын хугацаанд сургуулийнхаа орчинд ямар нэгэн хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртсөн бол хаана хэнд хандсан бэ?
